

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар

2021 оны жилийн эцэс,

Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Үнэлгээ
МУ-ын хууль				
1	Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26	43.3.. Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. (43.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. 43.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.)	Сүхбаатар сумын нутагт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Цайрт минерал” ХХК 240,2 сая төгрөг, туслан гүйцэтгэгч “Хун ша и жань” ХХК 726,6 са төгрөг, туслан гүйцэтгэгч “Үйлдвэрлэлийн барилга байгууламжийн корпорац” ХХК-иас 172,2 сая төгрөг нийт 1,139 сая төгрөгийн төлбөрийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Сүхбаатар сумын ИТХ-аас баталсан журмын дагуу эрүүл мэндийн салбарт түргэн тусламжийн машин, эрүүл мэндийн төвийн барилгын их засвар зэрэг ажлуудад 237,6 сая төгрөг, боловсролын салбарт Сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, урлаг заалны засвар, спорт заалны тоног төхөөрөмж шинэчлэл, цэцэрлэгийн тоглоом наадгай авах, багш нарын хөгжлийн дэмжих зэрэг ажилд зориулан 232,7 сая төгрөг хөрөнгө оруулалтыг шийдвэрлэн ажилласан байна.	100
2	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16	5.3.. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно. (5.2.Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.)	Байгалийн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 6 нөхөрлөл албан ёсоор байгуулагдаж үйл ажиллагаа явуулдаг. 2021 онд Дарьганга суманд шинээр 1 нөхөрлөл байгуулагдсан. Аймгийн хэмжээнд байгаль орчны нөөц баялагийг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр 2021 онд 3 сумын 3 нөхөрлөлийн үйл ажиллагаанд зориулж нийт 8 сая төгрөгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлсэний үр дүнд: -Дарьганга сумын Нарт нөхөрлөл Нартын ууланд нутаглаж БТЗ болон Аргаль хонины шилжилт хөдөлгөөн, тархацыг тогтоох зорилгоор хөдөлгөөн мэдрэгчтэй автомат камер 1 ш байршуулахад Аргаль хонь, үнэг хярс, Монгол тарвага бор туулай зэрэг амьтдын зураг давхардсан тоогоор 3500 орчим дүрс камерт буусанаас гадна нөхөрлөлийн гишүүд анхан шатны судалгааны арга зүйг эзэмшиж чадвахжсан. Мөн тус сумын Хишиг	100

			нэмэх нөхөрлөл нь 1 га газарт нялх бургас хашиж хамгаалснаас гадна ТХГН болох Холбоогийн нуурын хог хаягдлыг цэвэрлэсэн. -Түмэнцогт сумын Түмэн барбарис нөхөрлөл нь Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг Түмэнцогт, Мөнххаан, Хөлөнбуйр сумдын 80 малчин өрх, 21 хадлангийн салаанд хийж нийт 500 орчим хүн хамруулсан. 2021 онд хээрийн түймэр гараагүй болно. Дэмжлэг үзүүлсэн нөхөрлөлүүдийн хариуцсан бүс нутагт 2021 онд ан агнуурын зөрчил болон ой хээрийн түймэр гараагүй болно.	
3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;	Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн маягт, чиглэлийн дагуу нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг нэгтгэж, захиргааны статистик мэдээлэл, бусад тайлангийн хамт 2022 оны 1 дүгээр сарын 10-нд хүргүүллээ. 2022 оны судалгааны дүнгээр аймгийн хэмжээнд нийт нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын 43.0 хувийг, үүнээс төрийн захиргааны албан хаагчдын 61.0 хувийг, төрийн үйлчилгээний албан хаагчдын 47.0 хувийг, төрийн улс төрийн албан хаагчдын 17.7 хувийг эмэгтэй албан хаагчид тус тус эзэлж байна.	100
4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж 270 өрхийг зорилтот бүлэг болгон сонгон үйлчилгээгээ хүргэж хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Ковид-19 өвчин гарсантай холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 46 өрхөд хүнс тэжээлийн, 65 хүүхдийг дархлаажуулалт, ариун цэвэр, ариутгалын бүтээгдэхүүнээр дэмжлэг үзүүллээ.	100
5		18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зардалд орон нутгийн төсвөөс 90,0 сая төгрөгийг төсөвлөн хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг даргын 2021.05.11-ний өдрийн А/271 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтаар “Шилдэг хамтарсан баг”, шалгаруулах журмыг баталж, орон нутгийн төсөвт жил бүр 1,5 сая төгрөгийн урамшуулал олгогдсон	100

		Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)		
6		18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Япон улсын ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр Азийн хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлж байгаа “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” 9198-МОН төслийн хүрээнд тус аймгийн цагдаагийн газрын дэргэд 240 сая төгрөгийн төсөв бүхий хамгаалах байрыг “И Эс Мон” ХХК гүйцэтгэн ашиглалтанд оруулсан.	100
7		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн боловсрол олгох захиалгат сургалтыг танхимаар болон цахимаар давхардсан тоогоор 100 албан байгууллагыг хамруулан зохион байгуулсан. Байгууллагуудад гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр орон нутгийн телевизээр “Хүүхдийн эрхийн тухай” хуулийн танилцуулга /шторк ,9 төрөл/ “Нэг дүгээрт хүүхэд” цахим тоглолт, “Хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн боловсрол олгох”, “Угийн бичиг хөтлөх арга зүй” цуврал хичээл, “Хүчирхэг охид” ток шоу, “Аав & би”, “Хайрын түүх” 10 дугаар нэвтрүүлгийг тус тус бэлтгэн хүргэлээ. Нийт давхардсан тоогоор 88 удаагийн арга хэмжээнд 11628 иргэн хамрагдсан байна. Орон нутгийн “Сүхбаатарын өнгө” сонинд 2 удаагийн мэдээлэл, сурвалжлага зэргийг олон нийтэд мэдээлсэн.	100
8		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Баруун-Урт суманд баг бүрт хамтарсан баг байгуулан хамтарсан багийн тоог нэмэгдүүлж 22 болгон, Баруун-Урт сумын 9 багийн хамтарсан багт 4 удаагийн кейс конференци зохион байгуулж, практикт суурилсан кейсийн хариу үйлчилгээ үзүүлэх арга зүйгээр хангаж, 29 кейст үйлчилгээ үзүүлж, кейсийн бүрдүүлэлт хийж хаасан байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран 13 хамтарсан багт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн хамтарсан багийн мэргэжилтнүүдэд чиглэл өгч ажиллах ментор багш бэлтгэх сургалтыг 2 өдөр цахимаар зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2021.05.11-ний өдрийн А/271 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтаар “Шилдэг хамтарсан баг”, шалгаруулах журмыг баталж , орон нутгийн төсөвт жил бүр 1,5 сая төгрөгийн урамшуулал олгохоор журамлан ажиллаж байна.	100

9	19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн Иргэдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн 09 дүгээр “Түр хамгаалах байр”-ны харьяалал тогтоох тухай тогтоолоор аймаг орон нутгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилго бүхий шинээр баригдсан стандартад нийцсэн “Түр хамгаалах байр”-ыг аймгийн Цагдаагийн газарт хариуцуулан ажиллаж байна.	100
10	19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Орон нутгийн төсөвт хамгаалах байрын зардалд 90,0 сая төгрөгийг тусган хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлыг 2022 оны орон нутгийн төсөвт 90,0 сая төгрөгийг тусган аймгийн Иргэдийн хурлаар батлуулсан.	100
11	19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсөвт хамгаалах байранд 90,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	100
12	19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, түр хамгаалан байрлуулах үйлчилгээг 74 насанд хүрэгч, 21 хүүхдэд сэтгэлзүйн тест оношилгоо хийж, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг үе шаттайгаар зохион байгуулсан Жилийн эцсийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл, цагдаагийн газраас холбон зуучлах хуудсаар 142 кейс ирүүлснийг харьяа хамтарсан багт шилжүүлэн, хамтарсан багийн үйлчилгээг үзүүлэн, 83 кейст хамтарсан багийн үйлчилгээ үзүүлж шийдвэрлэсэн байна	100
13	19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх;	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай гэрээний үндсэн дээр санхүүжилт хийгдээгүй байна. Санал	100

		(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	гаргасан болон хүчирхийллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ одоогоор аймагт байгуулагдаагүй байна.	
14		19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах ажлын хүрээнд Аймгийн засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн а/271 захирамжаар “Хүүхэд, гэр бүлд ээлтэй сум, байгууллага”, “Шилдэг хамарсан баг”, “ Шилдэг эцэг эхийн зөвлөл” шалгаруулах уралдааны удирдамжийг батлуулан, үнэлгээ дүгнэлт хүлээгдэж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Хэрсүү гурвалжин , хөршийн холбоо арга хэмжээг зохион байгуулан гэр бүлийн хүчирхийлэлтэй дуудлага мэдээллийг иргэд, хөршөөр дамжуулан хүлээн авч ажилласан. “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” аяны хүрээнд Хууль зүй дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2017 оны 03 сарын 22 ны өдрийн А/63,А/48, А/106 журмын дагуу “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт”-ыг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж цагдаагийн газарт баривчлагдсан 6 иргэнийг сургалт нөлөөллийн ажилд хамруулсан	100
15		25.2.. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.	Аймгийн Цагдаагийн газарт 2004 оноос эхлэн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргийн асуудлыг 1 байцаагч хавсран гүйцэтгэж байсан ба Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ батлагдсанаас хойш Гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан орон тооны байцаагчийг дангаар нь ажиллуулж эхэлсэн. 2021 онд тус байцаагч нь гэр бүлийн хүчирхийллийн 41 хэрэгт байцаалт явуулсан ба өмнөх оны мөн үеэс 66 хувийн өсөлттэй байна. Тус онд энэ төрлийн гарсан зөрчлийн тоо 139 байна.	100

16	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3.. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Мерит төслийн байгууллагад удаа дараа санал хүсэлт тавьсны үр дүнд Аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын нэгдсэн суурь судалгаа боловсруулах ажил 90 сая төгрөгний санхүүжилтээр төрийн албан хаагчийн хүний нөөцийн суурь судалгаа хийгдэхээр болж, судалгааны бэлтгэл ажил бүрэн хийгдсэн байна. 2022 оны 3 сард судалгааны ажил дуусч аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ. Одоогоор төрийн байгууллага бүр сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна.	100
17	Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01	8.1.. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.	Аймгийн ИТХ 2019 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10/04 тоот тогтоолоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн ажлын байр,лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа,үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг 1 хувиар, хувиараа зорчигч эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг 5 хувиар тогтоосон. Мөн аймгийн ИТХ-аас үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хэмжээ болон авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг тогтоож мөрдөж ажиллаж байна. 2021 онд татварын хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй.	100
18		8.5.. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6,2 заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 199 дугаар тогтоолыг дагуу аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоосон. 5000,0 мян төгрөгийн төлөвлөгөөний биелэлтийг 28250,0 мян төгрөг төвлөрүүлж 188,3 хувийн гүйцэтгэлтэйгээр аймгийн төсөвт, АИТХ-ын тогтоолын дагуу 133990,0 мян төгрөгийн төлөвлөгөөг 139145,0 буюу 103,8 гүйцэтгэлтэйгээр орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Хэрэгжсэн хасах саналтай байна.	100

19	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	16.4.. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	Гамшгийн аюулын үед аймгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх түр /хоргодох/ байрыг аймгийн төвийн төр, хувийн хэвшлийн 15 байрыг томилгоожуулж, шаардлагатай материал хэрэгслээр хангах, нөөцийн тооцоо судалгааг 7, 14, 30 хоногоор гаргаж аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралтад оруулж тодотгол хийн ажиллаж байна. Монос, МЭЙК “Баруун-Урт” ЭХНБ-уудтай хариуцлагын гэрээ байгуулан мэргэжил арга зүйгээр ханган Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгалын бодисын нөөцийн судалгаа авч аймгийн нөөцийг 52 нэр төрлийн эм, хэрэгслийн 5-12 хоногийн тогтмол нөөц бүрдүүлэн Баасан гараг бүр УОК-ын Нэгдсэн Шуурхай штабт мэдээлж ажиллаж байна. Коронавируст халдварын үед тусгаарлан ажиглах байрны бэлэн байдлыг 13 сумдад нийт 38 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран бэлтгэл бэлэн байдлыг хангах гэрээг байгуулан томилгоожуулж Улсын онцгой комисст хүргүүлсэн.	100
20	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	15.2.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан үйлчлэх хугацаанаас зургаан сарын өмнө батална.	Аймгийн таван жилийн үндсэн чиглэлийн төслийг бүх салбар, сумдаас санал авч боловсрууллаа. Уг ажлыг хэрэгжүүлэхдээ шинээр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол улсын таван жилийн Үндсэн чиглэлд нийцүүлэн, салбар бүртэй хамтран хэлэлцэн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг хуулийн шаардлагад нийцүүлэн томьёолж боловсрууллаа. Боловсруулахад хуулийн шаардлагыг хангахын тулд Мерит төслийн дэмжлэгээр Удирдлагын академийн багш Ё.Батсүх багшийн зөвлөмжийг уг баримт бичгийн төсөл дээр авч сайжруулан боловсруулж ҮХГ төслийг хүргүүлэн санал дүгнэлт авч түүнийг нэмж тусган АИТХ-р батлуулсан. Зорилго, зорилт, хүрэх үр дүн бүрт тохирсон 1 болон түүнээс доош тооны шалгуур үзүүлэлтүүдийг загвар хүснэгтийн дагуу боловсруулж улсын үндсэн чиглэлтэй уялдсан хүрэх үр дүнгүүдийг тодорхойллоо. Үндсэн чиглэлийн төсөл нийт 8 зорилго, 37 зорилтод чиглэсэн 136 хүрэх үр дүн, тэдгээрийг хэмжих 302 шалгуур үзүүлэлтүүдийг агуулсан	100

21		17.4.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, агентлаг албад, сумдаас санал авч аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хуулийн хугацаанд нь боловсруулсан. Боловсруулахад хуулийн шаардлагыг хангахын тулд Мерит төслийн дэмжлэгээр Удирдлагын академийн багш Ё.Батсүх багшийн зөвлөмжийг уг баримт бичгийн төсөл дээр авч сайжруулан боловсруулж ҮХГ төслийг хүргүүлэн санал дүгнэлт авч түүнийг нэмж тусган АИТХ-р батлуулсан. Зорилго, зорилт, хүрэх үр дүн бүрт тохирсон 1 болон түүнээс доош тооны шалгуур үзүүлэлтүүдийг загвар хүснэгтийн дагуу боловсруулж хавсралтаар батлуулсан.	100
22		18.6.. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.	МУ-ын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан Агентлаг албад хэлтэс, сумдаас санал авч аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж ҮХГ хүргүүлсэн. ҮХГ-с ирүүлсэн санал дүгнэлтийг тусган АИТХ-д оруулан батлуулсан. Уг баримт бичгийг боловсруулахдаа 2022 оны улсын болон орон нутгийн төсвийн төсөлтэй төсвийн эх үүсвэрийг уялдуулан нийт 145 төсөл, арга хэмжээг төлөвлөж эдгээрийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшинг тодорхойллоо.	100
23		21.6.. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайлан, мэдээ тогтоосон хугацаанд, шалгуурын дагуу хүргүүлж байна.	100
24	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/	38.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд ёс зүйн дүрмийг Хурал батална.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн төслийг төлөөлөгчдөд танилцуулан 2021 оны 12 сарын 03-ны өдрийн Аймгийн ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн Төлөөлөгчдийн саналаар ИТХ-ын Ёс зүйн хороо, Хууль зүй, төрийн байгуулалтын хороодын хамтарсан хэлэлцүүлгээр оруулан дараагийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэлээ.	100

25	2020-12-24 Дугаар 2022.01.01	44.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.	Аймгийн ИТХ-ын 33 Төлөөлөгч хуульд заасны дагуу тус бүр үнэмлэх, энгэрийн тэмдэгтэй бөгөөд тус тус хэвлэмэл хуудас ашигладаг болно.	100
26		46.9. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож, тогтоолоор батална.	Хуульд заасны дагуу аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан ИТХ нь анхдугаар хуралдаанаараа Хуралдааны дэгийг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100
27		45.5. Хорооны үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно.	Аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан ИТХ нь анхдугаар хуралдаанаараа зохион байгуулалтын асуудлаа хэлэлцэн аймгийн ИТХ-ын дэргэд 6 хороо байхаар тогтоож бүрэлдэхүүн болон ажиллах чиглэлийг баталсан. Үүнд: Хууль зүй Төрийн байгуулалтын хороо, Уул уурхай байгаль орчны хороо, Хүнс, ХАА, үйлдвэрлэл үйлчилгээний хороо, Нийгмийн бодлогын хороо,Төсөв санхүү, эдийн засгийн хороо, Хот байгуулалт дэд бүтцийн хороог тус тус байгуулсан. ИТХ-ын Төлөөлөгч ёс зүйн дүрэмтэй байх нь хуульчлагдаж Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэн ажиллах Ёс зүйн хороог байгуулах шаардлага үүсэн ИТХ-ын хуралдаанаар Ёс зүйн хороог нэмж байгуулан бүрэлдэхүүн, ажиллах чиглэлийг баталж ИТХ нь 7 хороотой үйл ажиллагаа явуулж байна.	100
28		54.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.	Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурлын орон тоо, цалингийн сангаа тогтоохоор ажлын байрны шинжилгээ, судалгааны ажлыг хийж байна. 2021 онд төсөвт батлагдсан орон тоогоор ажиллалаа.	100
УИХ-ын тогтоол				
29	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч	Аймгийн хэмжээнд Хүүхдийн эрхийн улсын байцаагч 1 ажиллаж байна. Ковид гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж улсын хэмжээнд хөл хорионы дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд зарцуулахаар нөөцөлсөн, 13 сургууль, Боловсрол-Өргөө НДБайр, 23 цэцэрлэгийн хүнсний үлдэгдлийг зорилтот бүлгийн 1134 хүүхдэд 12 нэр төрлийн нэг бүр нь дунджаар 66850	100

	2021-07-07 Дугаар 2021 №67	нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	төгрөгний багцийг Харьяа ЗДТГ-ын халамжийн байцаагч, Хүүхэд хамгааллын мэргэжилтэн,Эцэг эхийн зөвлөл сургуулийн нийгмийн ажилтны хамтарсан баг нийтдээ 75 сая төгрөгний хүнсний нөөцийг түгээсэн байна. ЕБС-34,7 сая,СӨБ-40,3 сая Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа зорилтот өрхийн 627 хүүхдэд 50545218 төгрөгийн үнэ бүхий хоол хүнс, хувцас, түлээ нүүрсний дэмжлэгийг БШУСайдын А/162 дугаар тушаал, ЗГ-ын 188 тогтоолын дагуу цэцэрлэгийн хүүхдийн хүнсний үлдэгдэл болон багш, ажилчдын хандив, ААН байгууллага албан газрын хандив тусламжаар хүргэсэн. Мөн БШУСайдын 2021-08-12-ны өдрийн А/279 тоот тушаалын дагуу цэцэрлэг,ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрны ариутгалын зардалд 9979,2 мянган төгрөгний дэмжлэгийг нэмэлт дансаар нь дамжуулан олголоо	
УИХ-ын байнгын хорооны тогтоол				
30	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)	Хүн амын дундах сүрьеэ, ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, БЗДХӨ-ийг бууруулах асуудлыг “Халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-т тусган хэрэгжилтийг ханган жил бүр орон нутагт явуулын үзлэг шинжилгээг сум, багуудад зохион байгуулж ирснээс 2021 онд Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан Асгат Халзан Баяндэлгэр, сумдад мөн Баруун-Урт сумын 8-р багийн зорилтот бүлгийн 1451 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулж шинэ тэмбүү -11 хуучин тэмбүү -38 илрүүлж илэрч хавтлын хамт эмчлэн эрүүлжүүлж хяналтанд авч ажилласан байна.Мөн хүн амын дунд сүрьеэ, ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг танхимаар болон цахимаар тогтмол явуулж ХДХВ/ДОХ-той тэмцэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлж хүн амыг БЗДХ-аас сэргийлэх мэдээ, мэдээллээр ханган ажиллаа. Сүрьеэ өвчний нийт 46 тохиолдол бүртгэгдсэн энэ нь өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор, 10.000 хүн амд 3,2 промилиор буурсан байна. Сүрьеэ, БЗДХ-ын чиглэлээр ЭМБ-ийн ажилчдад Цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 570 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан, сургалтын өмнө болон дараах сорилоор	100

			мэдлэгийг үнэлэхэд 25%-иар өссөн үзүүлэлттэй байна. Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд хавьтлыг илрүүлэх үзлэг зохион байгуулах хамтран ажиллах гэрээний дагуу 13 суманд үзлэгт 2489 хүн, рентген шинжилгээнд 2070, лабораторийн онош баталгаажуулах шинжилгээнд 122 хүн хамрагдаж 8 хүн эерэг гарч эмчилгээнд бүрэн хамруулж хавьтлыг судалж илрүүлж ажиллаж байна. 120 хүнд туберкулины сорил тавьж 8 эерэг илэрсэн. Сургалтанд 711 иргэн хамрагдсан. Сүрьеэгийн тандалт оношлогоо эмчилгээний стандартаар эрүүл мэндийн төвийн 141 мэргэжилтэнд сургалт явуулсан байна. Өвчлөл 2018 он 2019 он 2020 он Сүрьеэ 64 87 68 БЗДХ 361 383 284	
31	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга	2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Хүн амын дундах ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, БЗДХӨ-ийг бууруулах асуудлыг аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх жилийн болон 5 жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллаа. Аймгийн хэмжээнд 2021 оны 11 сарын байдлаар 14087 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 2193.6 ногдож нийт бүртгэгдсэн халдварт өвчний дотор БЗДХ 219 буюу 1.5 хувийг эзэлж байна. БЗДХӨ нь 2020 оны мөн үеэс 48 тохиолдлоор буурсан байна.	100
32	хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	2021 онд эрүүл мэндийн салбарт БЗДХ болон халдварт өвчнөөс сэргийлэх , хариу арга хэмжээ авах хамгаалах хэрэгсэл, хувцас, ариутгалын бодис, урвалж оношлуур, багаж хэрэгсэл нийлүүлэхэд нийт 978,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байгууллагуудын гамшгийн эрсдэлийн сангаас 291,9 сая төгрөг гарсан.	100
33	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан	Коронавириуст халдварын цар тахлын үед хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор энэ талаар мэдээ мэдээлэл авах тусгай дугаарын утас бүхий санамж сэрэмжлүүлгийг 3000 ширхэг хэвлүүлэн иргэдийн худалдан авалт ихээр хийдэг дэлгүүрүүдээр дамжуулан хүнсний бараа,	100

	арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	бүтээгдэхүүний сав баглаа боодолд наан иргэдэд хүргэх ажлыг зохион байгууллаа. Мөн гэр хорооллын хүнсний дэлгүүрийн 23 худалдагч, худгийн 9 ус түгээгч нартай уулзалт зохион байгуулан мэдээ мэдээлэл солилцон зөвлөмж өгч,үйлчлүүлж байгаа иргэдээс хүчирхийлэлд өртөж хохирсон байж болзошгүй талаар олж мэдсэн мэдээллийг цагдаагийн байгууллагад хэрхэн өгөх талаар 52 ширхэг гарын авлага өгсөн. Ингэснээр гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх,таслан зогсоох,хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа “Хамтарсан баг”-ийг чадахуулах зорилгоор цахим сургалт,уулзалт, хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулж,хамтарсан багийн гишүүд болон сумдын хэсгийн төлөөлөгч нарыг хамруулсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 216 гомдол, мэдээлэл ирсэн ба үүнээс шаардлагатай 155 хохирогчийн мэдээллийг ГБХЗХГ, Хамтарсан баг”-т “Холбон зуучлах үйлчилгээний журам”-д заасны дагуу хүргүүлэн, хохирогчийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ гаргах болон хохирогч хамгааллын ажлыг зохион байгууллаа. 16 ЕБС-д 19 мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллаж байна.	
Ерөнхийлөгчийн зарлиг				
34	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Аймгийн хэмжээнд 73 төрийн байгууллага, 10 аж ахуйн нэгж монгол бичгээр гадна хаягжилт хийссэнээс гаднах гэрлэн хаягийг 16 байгууллага хийсэн . “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Титэм-Арт” академитай хамтран Сүхбаатар аймгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид, ЕБС-ийн багш, сурагчдын дунд “Жаахан шаргын нутаг” монгол бичгийн онлайн уралдааныг зохион байгуулж, 600 гаруй албан хаагч, багш сурагчдын бичвэрийг хүлээн авч, цэгцлэн, нэг бүрчлэн үнэлгээ өгч шалгарууллаа. 39 байгууллагын 390 албан хаагчийг хичээнгүй бичигт сургасан ахицтай. Тус уралдаанд нийт 1,5 сая төгрөгийн урамшуулал Хичээнгүй бичгийн уралдаанд 200 гаруй сурагчид оролцсоноос 48 сурагчдад аймгийн Засаг даргаас 1680,0 мянган төгрөгийн дэмжлэг	100

			үзүүлсэн. Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран төрийн албан хаагч, архив бичиг хэргийн ажилтан, монгол хэлний багш нарыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. Сум бүрт хэлний бодлогын зөвлөл байгуулсан. Сургалтын үйл ажиллагаанд зориулан 1.5 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.	
35		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Монгол хэл, бичгийг дээдлэгч сум, байгууллага, мэргэжлийн багш, иргэнийг шалгаруулах уралдааны болзлыг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан , жил бүр 8,0 сая төгрөгийн урамшуулал олгогдохоор журамласан.	100
36		1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	2021 онд Баруун-Урт сумын ерөнхий боловсролын I, II, III, IV сургууль, Онгон, Наран, Халзан, Дарьганга сумдын ерөнхий боловсролын сургуулиуд ийн ойр орчимд хүнсний худалдаа эрхэлж байгаа 15 газрын үйл ажиллагаанд шалгалт хийж, 8 зөрчил дутагдал илрүүлэн түүнийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, 40 заалт бүхий 15 зөвлөмж хүргүүлэн биелэлтийн хангуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.	100
37	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	2.. Амьд явах, амдрахын сайн сайхныг олон нийтэд сурталчилан таниулах, дээрх агуулага бүхий бүтээл, нэвтрүүлэг, мэдээлэлд ард иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг идэвхийлэн оролцохыг уриалсугай.	Иргэдийн санаачлагаар гэр бүл хүүхэд залуусыг ном уншуулах зорилгоор “Судар эгшиглэн” төслийг цар тахлын хорио цээрийн дэглэм болон жилийн турш амжилттай хэрэгжүүлсэн. Тус төсөлд 300 гаруй иргэд, залуучууд оролцож шинээр уншигчдын тоо нэмэгдүүлэн, гэр бүл, хамт олон, байгууллагаараа ном уншиж, ХБХ иргэд хүртэл аудио номыг уншиж тус төсөл арга хэмжээнд оролцсон. Төслийн арга хэмжээг Соёлын яам 4,5 сая төгрөг, УИХ гишүүн 14,0 сая төгрөгөөр санхүүжүүлж дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдэдээ хөдөлгөөн засал болон хөгжлийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх чиглэлээр 6 цуврал теле хичээл, “Сэтгэл зүйч зөвлөж байна” зөвлөгөө, өсвөр үе, залуучуудын биеийн тархлаа, хөдөлгөөнийг дэмжих зорилгоор алхах, гүйх, дасгал хөдөлгөөн хийх, Гэр бүлийн боловсрол олгох сургалтын хүрээнд “Шинжлэх ухааны үндэслэлтэй угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт цуврал хичээл, Гэр бүлийн	100

			радиотой хамтран сурагч оролцуулан подкаст хийж , орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл телевизээр дамжуулан иргэдэд хүргэлээ	
38	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_23	1.1. Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх.	Аймгийн хэмжээнд 10 хичээлийн дунджаар 2021 онд 520,4 оноо авч, өмнөх жилээс 2,9 хувиар өссөн үзүүлэлттэй. Сум бүрээс ЭЕШ өндөр оноо авсан сурагчдыг гадаадын их дээд сургуульд элсэн суралцах эрхийн бичгээр 13 сурагчид шагнуулсан. Аймгийн Засаг дарга 800 оноо авсан 4 сурагчдад тус бүр 500,0 төгрөг, бэлтгэсэн багшид тус бүр 200,0 төгрөгийн, нийт 2,8 сая төгрөгийн урамшуулал олгосон.	100
39	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Ойн салбарын үндэсний чуулган 2021.11.15-нд зохион байгуулагдсан. БОАЖЯ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, аймгийн Засаг дарга нартай "Тэрбум мод" хөдөлгөөнийг дэмжих хүрээнд хариуцлагын гэрээ байгуулсан. Гэрээнд 10.0 сая мод тарих, орон нутгийн хөгжлийн сангаас тодорхой хувийг зарцуулах талаар гэрээнд тусгасан. 11-р сарын 08-14-ны өдрүүдэд "Тэрбум мод" хөдөлгөөнийг зохион байгуулах төлөвлөгөө, арга замын талаар 4 салбар хуралдаан болсон. Орон нутгийн төсөв, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал, төсөл хөтөлбөр, иргэдийн өөрийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийт 28.587 мод тарьж ургуулахад 161.609.600 төгрөг зарцуулсан.	70
40		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58-р зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын А/569 дугаар захирамж гарч "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр-ийг зохион байгуулан ажилласан. Мод тарих аргачлал, зөвлөмж, мэдээллийг аймгийн цахим мэдээллийн хэрэгсэл, БОАЖГ-ын цахим хаяг, BBS TB-р дамжуулан олон нийтэд түгээсэн. Аймгийн төвд зохион байгуулагдсан "Намрын ногоон өдрүүд Сүхбаатар аймагт үйлдвэрлэв-2021" үзэсгэлэн худалдаанд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, 3 ААНБ-ууд 6 зүйлийн мод суулгацаар оролцож, ААНБ, иргэдийг мод суулгацаар хангаж, 850 иргэнд мод тарих арга зүйн,	70

			гарын авлага болон холбогдох мэдээллийг хүргэж ажилласан.	
41		1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Сүхбаатар аймагт 2021-2028 он хүртэл хэрэгжиж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлд усны нөөцийг бүрдүүлж мод тарьж ургуулах зорилгоор хөв цөөрөм, усан сан байгуулах саналыг хүргүүлсэн.	70
42		1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарилгын хүрээнд аймгийн хэмжээнд 2022-2030 онд хэрэгжих ногоон байгууламж нэмэгдүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж байна. Хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд одоогийн байдлаар Баруун-Урт, Дарьганга, Мөнххаан, Түвшинширээ, Түмэнцогт сумд нийт 108.46 га газрыг мод бут сөөг тарих зориулалтаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусгасан байна.	70
43		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Аймгийн Засаг даргын 2021 оны А/186, 2021 оны А/569, 2021 оны А/555 дугаар захирамжууд тус тус гарсан, энэ хүрээнд: Зэвсэгт хүчний 338 дугаар анги “Тэрбум мод” хөдөлгөөнд нэгдэж нийт 1200 ш мод тарьсан, мөн аймагт хэрэгжиж буй “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төслөөс 3 суманд нийт 2000 ш 4 зүйлийн мод сөөгийг хандивлаж бусад байгууллага, олон нийтэд мод тарих үйлсэд идэвхтэй оролцохыг уриаллаа. Аймгийн хэмжээнд: 1560 айл өрх хашаандаа - 8401, ААНБ-ын орчинд -13964,Баг хооронд – 6222, Зүлэгжүүлэлт – 1937 м2 тарихад 159 ААНБ, 5234 иргэн оролцож, 161.609.600 төгрөг зарцуулсан. Нийт 28.587 мод тарьж ургуулсан. Аймгийн төвийн хувь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд 172.5 сая төгрөг зарцуулсан үүнд: 1.Мод тарих ажилд 50.0 сая төг 2. Сүхбаатар-Ойжуулалт СДОАнгид усалгааны машин 60.0 сая төгрөгөөр шийдвэрлэсэн.	100

			3.Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн талбайн 23.000 гаруй модны усалгаа, арчилгааны ажилд 52.5 сая төг, мод 88,9%-н ургалттай	
ҮАБЗ-ийн зөвлөмж				
44	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Аймгийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг судалгааг гарган БХБЯ-д хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэгийг 2021 оны эхэнд шинэ барилгад шилжиж орсон, мөн Баруун-Урт сумын А бүсэд байрлах хуучин больницын байрыг дахин төлөвлөлтөнд оруулж орчин үеийн шийдэлтэй орон сууны хотхон болгохоор төлөвлөлт хийж зураг төслийн ажил хийгдээд байна. 2020-2021 онд Элит хороололд 18 айлын 2 эгнээ шинэ суурьшлын бүс үүсгээд дэд бүтцийн ажил бүрэн хийгдэж улсын комисс ажиллаж ашиглалтад оруулаад байна.	100
45		3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	2021 онд хувьд цар тахалтай холбогдуулан танхим болон олон нийтийг хамруулсан сургалт, цуглааныг хийгдээгүй болно. Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/356 дугаар захирамжаар зөвлөлийн бүрэлдэхүүний шинэчлэн байгуулж, ажлыг эрчимжүүлэх талаар Мэргэжлийн байгууллага болох аймгийн Онцгой байдлын газарт чиглэл өгч ажилласан. 2021 онд “Залуус хотхон” 2-р ээлжийн барилгын 4 айлын 5 балконы хаших бүтээц, тавцанд хэмжилт, бетоныг үл эвдэх аргаар шалгах, ан цавны байдалд дүн шинжилгээ, хэмжилт хийж баримтжуулж аваад дараагийн шатны арга хэмжээ авч ажиллалаа.	70
46	Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 2017-01-10 Дугаар 2017_03/03	3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоож, бүсэд мөрдөх журмыг БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар батлахаар төслийг Орчны бохирдлын үндэсний хороонд хүргүүлсэн.	70
47	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга	2.2. Хүн амын ундны ус хангамжийн баталгаат байдлыг хангах үүднээс хот, суурин газрын ус хангамжийн эрүүл бүсийг тогтоон, хамгаалалтад авч газар олголт хийхгүй байх, газар чөлөөлөх ажлыг орон нутгийн удирдлагууд шуурхай зохион байгуулах.	Баруун-Урт сумын хүн амын ундны ус хангамжийн эх үүсвэр Шовдол нь Баян шарга ууланд харьяалагддаг бөгөөд Баяншарга уул орчмын 331569.175 га газар нутгийг 30 жилийн хугацаатайгаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 сарын 03 өдрийн 07 дүгээр тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.	100

48	хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	2.3. Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, усны нөөцийг бохирдох, хомсдохоос сэргийлэх зорилгоор усны сан бүхий хамгаалалтын бүсийн дэглэмийг хатуу мөрдүүлэх	2020 онд Аймгийн нутаг дэвсгэр дэх усны тоо бүртгэл, усны сан бүхий хамгаалалтын бүс тогтоох ажлыг 4 сав газрын захиргаатай хамтран хийхэд аймгийн хэмжээнд нийт 2340 худаг үүнээс Гүн өрмийн худаг 900, Гар худаг 1340, Булаг шанд-202 үүнээс, усгүй-35, нуур тойром-191, рашаан -14 тоологдсон. Усны сан бүхий хамгаалалтын бүс нийт- 325546.71 га, үүнээс онцгой хамгаалалтын бүс-177157.53га, энгийн хамгаалалтын бүс-129034.38га, Хүн амын төвлөрсөн усан хангамжийн худаг аймгийн хэмжээнд нийт-50 худгийн эрүүл ахуйн бүсэд нийт-1084.78 га, хориглолтын бүс-72.77га, хязгаарлалтын бүс-1012.01 га талбай бүхий талбайд хамгаалалтын бүс тогтоох ажлын зураглалын ажлыг хийгээд байна. 2021 онд Сүхбаатар аймгийн усан сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын хэсгийн уулзалтыг УГГХДТСав газар, Буйр нуур мэнэнгийн талын сав газар, Хэрлэнгийн сав газар, Галба-Өөш долоодын сав газрын захиргаа, бүх сумдын хурлын дарга, байгаль хамгаалагч, аймгийн төсөвт байгууллагын дарга, холбогдох мэргэжилтэнгүүд нийт 84 хүний бүрэлдэхүүнтэй сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.	70
49		2.4. Томоохон голууд дээр усыг хуримтлуулан урсацын тохируулга хийх. усан сан байгуулах, нийт нутгийн хэмжээнд хур тундасны усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэн цөөрөм барих ажлыг эрчимжүүлэх замаар усны нөөцийгш нэмэгдүүлж,и хүн ам болон эдийн засгийн салбаруудыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх	Сүхбаатар аймагт томоохон гол мөрөн байхгүй. Хамааралгүй заалт хасах саналтай байа.	100
50		2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Сүхбаатар аймгийн төвд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах 3000м3/хоног хүчин чадалтай ногоон хэв загвар бүхий бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийн ажил 70%-тай үргэлжилж байгаа ба тус байгууламжийг 2022 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдад цэвэрлэх байгууламжтай. БХБЯ-ны захиалгаар манай аймгийн Наран, Баяндэлгэр, Дарьганга суманд хийгдэх санхүүжилт батлагдсан боловч энэ онд гүйцэтгэгч ирж газар дээр ажиллаагүй болно.	70

51		2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Цайрт минерал, Монголжүюаньли, Эм Эл Цахиурт овоо, Нутгийн анар, Кожеговь, Макс ойл ХХК-ууд усыг хэмнэлттэй хэрэглэх, зохистой ашиглах, үйлдвэрлэлийн бохир усны дэвшилтэт технологиор цэвэрлэж, 980 360м3 саарал ус дахин ашигласан байна. Сүхбаатар аймгийн төв, сум, суурины инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, халаалтын зуух, үерийн хамгаалалтын далан, суваг г.м/ тоо хэмжээ, хүчин чадал, ашиглалт, үйлчилгээний түвшингийн өнөөгийн байдлыг /чанар, насжилтийг/ тодорхойлсон судалгаа, мэдээллийг салбарын яаманд хүргүүлсэн байна.	100
52		2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах	Баруун-Урт сумын төвд 4.8 км урт үерийн ус татан зайлуулах системийн зураг төслийн даалгаврыг боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. 2022 оны БХБ сайдын багцын хөрөнгөөр зураг төслийг боловсруулах жагсаалтад тусгуулж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70
53	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Ойн салбарын үндэсний чуулган 2021.11.15-нд зохион байгуулагдсан. БОАЖЯ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, аймгийн Засаг дарга нартай "Тэрбум мод" хөдөлгөөнийг дэмжих хүрээнд хариуцлагын гэрээ байгуулсан. Гэрээнд 10.0 сая мод тарих, орон нутгийн хөгжлийн сангаас тодорхой хувийг зарцуулах талаар гэрээнд тусгасан. 11-р сарын 08-14-ны өдрүүдэд "Тэрбум мод" хөдөлгөөнийг зохион байгуулах төлөвлөгөө, арга замын талаар 4 салбар хуралдаан болсон. 2022-2030 онд ногоон байгууламж нэмэгдүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж байна. 2022 оноос хэрэгжиж эхэлнэ. Аймгийн Засаг даргын А/ 569 дугаар захирамжаар Ерөнхийлөгчийн 58-р зарлигийг хэрэгжүүлэх, "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр-ийг зохион байгуулах захирамж гарч ажлыг зохион байгуулсан. Мод тарих аргачлал, зөвлөмж, мэдээллийг тус аймгийн нэгдсэн зар, БОАЖГ-ын цахим хаягууд, BBS ТВ болон цахим хэлбэрээр түгээсэн. ААНБ, айл өрхийг тарих мод суулгацаар хангахаар Баруун-Урт хотноо зохион байгуулагдсан "Намрын	70

			ногоон өдрүүд Сүхбаатар аймагт үйлдвэрлэв-2021“ үзэсгэлэн худалдаанд 3 ААНБ, иргэн 6 зүйлийн мод суулгацаар оролцсон, 850 иргэнд мод тарих арга зүйн, гарын авлага болон холбогдох мэдээллийг хүргэж ажилласан. Аймгийн Засаг даргын 2021 оны А/186, 2021 оны А/569, 2021 оны А/555 дугаар захирамжууд тус тус гарсан, энэ хүрээнд: 1560 айл өрх хашаандаа - 8401 мод, ААНБ-ын орчин, сааданд – 13964 мод, Баг хооронд – 6222 мод, Зүлэгжүүлэлт – 1937 м2 тарихад 159 ААНБ, 5234 иргэн оролцож, 161.609.600 төгрөг зарцуулсан. Нийт 28.587 мод тарьж ургуулсан. Аймгийн төвийн хувь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд 172.5 сая төгрөг зарцуулсан үүнд: Шинээр мод тарих ажилд 50.0 сая төг, Сүхбаатар-Ойжуулалт СДОАнгид усалгааны машин 60.0 сая төгрөгөөр шийдвэрлэсэн. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн талбайн 23.000 гаруй модны усалгаа, арчилгааны ажилд 52.5 сая төг, модны ургалт 88,9%-тай.	
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл				
54	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03	1. 1. Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлт бүртгэх станц, боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэхэд гадаадын мэргэжлийн тэргүүлэх байгууллагуудтай хамтарч ажиллах, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох, төв суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барилгажуулах боломжтой газрыг тодорхойлох арга хэмжээ авах, (Аймаг, нийслэлийн Засаг дарга, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв)	Аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2018 онд Жэбминерал ХХК хийж аймгийн засаг даргын захирамжаар газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай зөвлөлийг 2021 онд 12 хүний бүрэлдэхүүнтэй шинчилэн байгуулж 4 зүйл 17 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж биелэлт 95% ханган ажилласан.	100
55		5. Орон сууц, олон нийт, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламжуудын газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлын үзлэг, шалгалтыг хийх, бүх барилгыг паспортжуулан ашиглалтын хэвийн нөхцөлөөр хангуулж, мэдээллийн сан байгуулах, бүсийн тулгуур төв, аймаг, нийслэлийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг хийх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан хамтарч ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх, (Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, аймаг,	Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр орон тооны бус зөвлөлийг байгуулан 16 аж ахуйн нэгжийн барилга байгууламжид паспортжуулалтын ажил хийгдээд байна. Мөн газар хөдлөлтийн үед нурах эрсдэл бүхий 63 барилга байгууламжийн судалгааг Газрын харилцаа хот байгуулалтын газар, мэргэжлийн хяналтын газартай хамтран гаргасан.	30

		нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар)		
56		6. . Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)	2021-2022 онд хийж хэрэгжүүлэх 3 зүйлийн 31 заалттай төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн ба биелэлт 88.4 хувь хангагдсан. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, видео хичээл,зөвлөмжийг "su.nema.gov.mn" цахим сайт, "Сүхбаатар урьдчилан сэргийлэх", "Сүхбаатар Онцгой байдлын газар" фэйсбүүк хаягаар дамжуулан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх,таниулах өдөр”-ийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цахимаар сурталчилсан. Газар хөдлөлтийн аюулгүй ажиллагаа,2 төрлийн богино хэмжээний сэрэмжлүүлэг шторк,бичлэг, теле хичээлийг орон нутгийн телевизээр 10 удаагийн давтамжтайгаар 8 хоног,нийт 100 удаа нэвтрүүлж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх 3 мэдээлэл бэлтгэн Сүхбаатар аймгийн 8 сайтад байршуулан иргэдэд сурталчилгааны ажлыг хүргэлээ. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах өдөр”-ийн хүрээнд Баруун-урт сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангитай хамтарсан дадлага сургуулийг Гал унтраах тактик, Газар хөдлөлтийн үеийн аврах ажиллагаа сэдвээр Гал түймэр унтраах, аврах 15 дугаар анги, Эрэн хайх аврах салбарын нийт 56 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан. Мөн Дарьганга, Баруун-Урт сумдад гамшгаас хамгаалах команд штаб,Онгон,Түвшинширээ сумдад иж бүрэн сургууль,дадлага,Мөнххаан,Уулбаян,Халзан,Баяндэлгэр сумдад бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж ажилласан. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулах ажлыг 13 сумд болон гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, 20 мэргэжлийн ангийн төлөөллийг хамруулан танхимын сургалтыг зохион байгуулж,чиглэл өгч ажиллалаа.Телевиз болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах зорилгоор теле хичээл өдөрт 3 удаагийн давтамжтай 8 хоног 24 удаа,Газар хөдлөлтийн шторк өдөрт 8 удаагийн давтамжтай 80 удаа иргэд олон нийтэд хүргэсэн.Сумын онцгой	100

			комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд мэдээллийг хүргэн ажиллалаа.	
57		7.. Гамшгийн үед онцгой горимоор ажиллах шаардлагатай дулааны цахилгаан станц, цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, түгээх байгууламж, тээвэр, ачаа, зорчигчийн терминал, харилцаа холбоо, телевиз, радио зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, химийн болон бусад хорт бодис, нян өсгөвөр бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга)	Сүхбаатар аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж Дөрвөлж орон нутгын өмчид газар, "ДБЭХС" ХХК-ний Сүхбаатар аймаг дахь салбар, Авто тээврийн төв, Мэдээлэл холбоо, цахилгаан холбоо зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, заавартай танилцаж хэрэгжүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Сүхбаатар аймгийн Онцгой комисс 29- удаа хуралдаж 141 асуудал хэлэлцэж 68 захирамж шийдвэр гаргаж орон нутгийн алба мэргэжлийн ангийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. "Химийн хорт болон аюултай бодисын тухай" хууль, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран 2017 оны 05 дугаар сарын 23-ны баталсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, устгах журам"-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монгол Улсын Шадар Сайдын баталсан "Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж"-д гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын хууль, стандарт, норм, нормативийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл бүхий "Цайрт минерал" ХХК, "Эм Эл Цахиурт овоо" ХХК, "Монгол Жуан Ли" ХХК-д химийн бодисын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг зохион байгуулан явуулж, дээрх компаниудын "Химийн ослын үед ажиллах төлөвлөгөө"-г хянаж заавар зөвлөмж өгч ажилласан.	100
58		11.. Барилга, хот байгуулалтын хууль, төлөвлөлтийн норм, дүрэм, журам, стандартын нөхцөл шаардлагыг зөрчсөн дутагдлыг арилгах, ялангуяа Улаанбаатар хотод ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй барилга барих, байшин хоорондын зайд норм зөрчин газар олгох явдлыг таслан зогсоох,	Баруун-Урт сумын 4, 6, 2 дугаар багуудад баригдаж байгаа нийтийн зориулалттай орон сууц, албаны болон хувийн зориулалтаар баригдаж байгаа барилга байгууламжууд хяналт тавьж, гадна тохижилт, цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийг батлагдсан зураг төсвийнх нь дагуу бий болгуулах, Баруун-урт болон бусад сум суурин газруудад баригдаж байгаа нийт барилга байгууламжуудын байшин хоорондын зай	100

		(Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)	хэмжээг холбогдох стандарт нормын дагуу барих талаар шаардлага хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна.	
ЗГ-ын тогтоол				
59	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	Аймгийн ЗД-ын А/155 дугаар захирамжаар “Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалья” уралдааныг аймгийн хэмжээнд зарлаж, уралдааны удирдамжийг бүх сумдад хүргүүлж, Сүхбаатарын өнгө сонинд хэвлүүлж олон нийтэд хүргэсэн. Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Наран, Онгон, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд угийн бичгийн уралдаан зохион байгуулж нийт 7,8 сая төгрөгийг шагналын санд зарцуулсан. Сумдад 36 удаагийн сургалт хийгдэж 901 иргэн хамрагдсан. Аймгийн уралдаанд 10 сумаас шалгарсан 14 байгууллага, 150 иргэн оролцсон ба шалгаруулалт хийж, шагналын санд 4,8 сая төгрөг зарцуулсан. Угийн бичиг хөтлөлт өнгөрсөн оны мөн үеэс 1,4 хувиар нэмэгдэж 41,9 хувь болсон. Аймгийн уралдаанд шалгарч ирсэн материалуудын үзэсгэлэн, шагнал гардуулах арга хэмжээг орон нутгийн ТВ-ээр дамжуулж, Сүхбаатарын өнгө сонинд мэдээ нийтлүүлсэн.	100
60	Журам батлах тухай 2015-06-29 Дугаар 2015_263	2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сүхбаатар аймаг нь БОАЖЯ-наас зарласан “Хоггүй цэвэрхэн монгол” аянд зүүн бүсээс 4 удаа шалгарч 4 сая төгрөгөөр шагнагдсан бөгөөд шагнал урамшууллыг хог хаягдлын чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ААНБ, байгаль хамгаалагч, тохижилтын ажилтан нарт олгоод байна	100
61	Журам шинэчлэн батлах тухай 2016-01-11 Дугаар 2016_29	2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.	Төрийн байгууллага, аж ахуйн нэгж нь шилэн дансны тайлангаа тогтмол илгээж, мэдээллэж хэвшсэн, 12 дугаар сарын байдлаар 137-н байгууллагын тайлан илгээлт 100 тай байна. Шилэн дансны цахим санд 2021 онд 137 байгууллага 20617 мэдээлэл оруулахаас 1855-н мэдээллийг оруулж 1762 мэдээллийн хугацааг хоцроож мэдээлсэн байна. Хугацаа хоцроосон байгууллагуудад зөвлөгөө мэдээлэл өгч зөрчлийг бүрэн арилган ажиллаж байна.	100

62	Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-05-23 Дугаар 2018_138	2.. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.	Ажлын байранд, ажлын цагаар олон нийтийн сүлжээнд хандахыг хориглосон заалтыг агентлаг, төсөв байгууллагуудын дотоод журамд оруулж, албан хаагчдад танилцуулан удирдлагуудын зүгээс хяналт тавин ажиллаж байна. ERP систем болон web мэйлийг төрийн байгууллагуудад бүрэн нэвтрүүлж байгууллага хоорондын албан бичиг солилцоонд ашиглаж байна.	100
63	Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай 2018-06-13 Дугаар 2018_171	3.. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймаг, нийслэлийн аялал жуулчлалын чиглэлүүдийг аялал жуулчлалын гол чиглэлтэй нийцүүлэн баталж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Монгол улсын ЗГ-ын 171 тоот тогтоолоор Монгол орны аялал жуулчлалын гол чиглэл, хил дамнасан болон хил орчмын аялал жуулчлалын чиглэлийг баталж гаргасантай холбогдуулан БНХАУ-ын Шилийн гол аймагтай хамтран хил орчмын аялал жуулчлалын 1 өдрийн, 3 өдрийн, 5 өдрийн аялал жуулчлалын маршрутыг тогтоож, хил орчмын аялал жуулчлалын чиглэлээр хятад монгол хэл дээр 1000 ширхэг товхимол гаргаад байна. Ковид цар тахалтай холбоотойгоор хил орчмын аялал жуулчлал удаашралтай байна.	70
64	Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай 2018-07-09 Дугаар 2018_225	2.. Энэ тогтоолын хавсралтад заасан мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг холбогдох хууль, заавар, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Орон нутгийн санхүүжилтээр Биокомбинат ХХК-тай Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, био бэлдмэл нийлүүлэх гэрээ хийж 2021 онд орон нутгийн төсвөөс Дуут хавдар, Цусан халдварт, ДХХ энтериобактериоз хам өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үнэ, үйлчилгээний хөлс, гүйцэтгэлийн хяналтын зардал болох 461.5 сая төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан төсөвт суулган Био комбинат ХХК-д вакцины үнэ 101.8 сая төгрөгийг, вакцины үйлчилгээний хөлс 357.3 сая төгрөгийг МЭҮН-д холбогдох баримт материалыг үндэслэн олгож, вакцины хяналтад 2.4 сая төгрөгийг зарцуулсан.	100
65	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах	1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын	Аймгийн агентлаг, албадын дарга, мэргэжилтэн нар болон сумдын Засаг даргын Тамгын газрын дарга мэргэжилтэн нарын 60 орчим албан хаагчид 2 удаа Төрийн албаны тухай хууль холбогдох бусад дүрэм,	100

	тухай 2018-08-22 Дугаар 2018_258	дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	журмаар арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн аймгийн удирдах албан хаагчдын зөвлөгөөний үед нийт 120 орчим албан хаагчид Төрийн албаны шинэтгэлийн хүрээний зорилт арга зүйг танилцуулж, хийж, хэрэгжүүлэх, анхаарч ажиллах үйл ажиллагааны талаар арга зүйн зөвлөгөө өгч, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр үүрэг чиглэл өгсөн. 2021 онд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллагаагүй Байгаль орчин аялал, жуулчлалын газрын дарга Х.Төмөрхуягт Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах тухай албан бичгийг аймгийн Засаг даргад хүргүүлснээр хариуцлага тооцуулж ажилласан.	
66		1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;	“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2021 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 16478 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 16129 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 97,8 хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй 267 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна. Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Нийгмийн даатгал, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст хандаж гарсан өргөдөл, хүсэлт зонхилж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар Аймгийн Засаг даргад хандаж бичгээр 52, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин 13 өргөдөл ирж 100 хувь шийдвэрлэсэн. Эдгээрээс зайлшгүй шаардлагатай нэг иргэнд 3.000.000 төгрөгний буцалтгүй тусламж олгож нэг иргэний тусгаарлах байрны зардлын 50 хувийг хөнгөлсөн байна.	100
67		1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн,	Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулсан. 422 иргэн бүртгүүлж, 365 иргэн шалгалтад хамрагдсанаас 113 иргэн тэнцэж, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн байна. Төрийн захиргааны	100

		мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг 2 удаа зохион байгуулж 85 ажлын байр зарласнаас 54 ажлын байр нөхөгдсөн байна.	
68		1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох;	Төрийн захиргааны удирдах албан тушаалын тусгай шалгалтыг 2 удаа зохион байгуулж 9 ажлын байр нөхөгдсөн байна. Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын тусгай шалгалтыг 2 удаа зохион байгуулж, 9 ажлын байр зарласнаас 9 ажлын байр нөхөгдсөн.	100
69		1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга холбогдох агентлаг, албадын дарга нарт 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 46, 47, 48 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 11 сарын 24-ны өдрийн 355 дугаар тогтоол болон албан бичгийг хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна. Дээрх албан бичгээр тухайн байгууллагад зөрчилтэй байгаа төрийн захиргааны албан хаагчийн томилгоог хүчингүй болгох, сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөрт багтаан ирүүлэх, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 355 дугаар тогтоолын хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд тайлагнах зэрэг үүрэг чиглэл өгсөн.	100
70		1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	Төрийн бүх байгууллагууд "Хөдөлмөрийн дотоод журам"-даа ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээний актад зааснаас бусад тохиолдолд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалтыг тусгасан. Мөн байгууллага бүр өөрийн дотоод хяналтын нэгж, ажилтны ажиллах төлөвлөгөөнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлыг тусган, хяналт тавин ажиллаж байна. Төрийн байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж журамд заасан хугацаанд	100

			заасны дагуу жилийн эцсийн тайлан мэдээг хүлээн авч байгаа тул ажлын байранд болон ажлын цагаар архи, согтууруулах ундааг хэрэглэсэн, уг зөрчилтэй холбогдуулан сахилга, хариуцлага тооцсон талаарх мэдээлэл нэгтгэгдэн гараагүй байна. Мөн Цагдаагийн газартай хамтран төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэж буй эсэхэд хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Хяналт, шалгалтын үр дүнд давхардсан тоогоор 7 байгууллагын 20 албан хаагчдад зохих журмын дагуу хариуцлага тооцуулан ажиллаж байна.	
71		1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Тайлант онд ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар архи, согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил дутагдал гаргуулахгүй байх талаар тухайн байгууллагуудад албан мэдэгдэл хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан ба энэ төрлийн зөрчилд тухайн байгууллагуудаас давтан илэрсэн зөрчил байхгүй байна. Мөн 2021 оны 11 дүгээр сард зөрчил илэрсэн байгууллагуудын алба хаагчдын сахилга хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж "Сахилга хариуцлагын зөвлөгөөн"-ийг улирал бүр хорио цээрийн дэглэмтэй холбогдуулан 24 агентлагийн удирдлага, хүний нөөцийн мэргэжилтэнг хамруулан анхааруулга, зөвлөмж, мэдээллийг өгөх сургалтыг цахимаар зохион байгуулсан.	100
72		1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрэмд өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд төрийн чиг үүргийг гүйцэтгэж буй бүх төрийн байгууллага/27 агентлаг, 5 төсөвт, 16 сургууль, 24 цэцэрлэг, 16 өрхийн эрүүл мэндийн төв, 12 соёлын төв, номын сан, сумын Засаг даргын Тамгын газар/-ууд "Хөдөлмөрийн дотоод журам"-д "Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах", "Байгууллагын удирдлага болон үүрэг хүлээсэн албан тушаалтан нь ажлын байрны бэлгийн дарамтын талаар гомдол гаргагчийн нууцлалыг хадгалах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд болон өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах",	100

			"Ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн албан хаагчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээллийг аливаа хэлбэрээр түгээх"-ийг хориглох заалтуудыг тусгуулан шинэчлэн батлаад байна. Уг хориглох заалтуудын хэрэгжилтэд байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжид тусган, хяналт тавин ажиллаж байна.	
73		3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар хамтран сумдын төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, хяналт, шалгалт хийх зорилгоор энэ оны 2 дугаар сард 13 суманд ажиллалаа. Тус ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон Төрийн албан зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүд орж ажилласан. Уг ажлын хэсэг нь 13 сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцан, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, шинэчлэл, гаргаж буй шийдвэр, ирцийн бүртгэл зэрэг баримт бичигтэй танилцан, хяналт, шалгалтыг хийлээ. Дээрх хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 4 бүлэг, 22 заалт аймгийн Засаг даргын 2021 оны 01 тоот албан даалгаварыг хүргүүлэн, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.	100
74	Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019-03-21 Дугаар 2019_111	2.. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.	Хөдөлмөрийн тухай хуулийн 111-ийн дагуу 2021 оны 1-р сард аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 25 буюу түүнээс дээш ажилчидтай 71 аж ахуйн нэгжүүдээс судалгааг авч нэгтгэв. Аймгийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран зарим аж ахуйн нэгж байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж буй эсэхэд шалгалт зохион байгуулж, шаардлага, зөвлөмж, чиглэлийг хүргүүлж ажилласан байна. 2021 онд ХБИргэн ажиллаагүй зардалд ХЭДСанд 69.6 сая төгрөгийг төвлөрөөд байна.	100

75	Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149	1.. Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	13 суманд “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулагдаж төрийн цахим үйлчилгээний операторууд нэгдсэн төвдөө байрлан иргэдэд цахимаар үйлчилгээ үзүүлж тогтмол ажиллаж байна. Мөн бүх операторуудад суурин утасны үйлчилгээг нэвтрүүлж иргэдээс өргөдөл гомдлыг хүлээн авах боломжтой болсон. Баруун-Урт сум нь 2019 онд төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулж төрийн байгууллагын бүх төрлийн үйлчилгээг иргэдэд нэг доороос түргэн шуурхай үзүүлж байна.	100
76		3.. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй.	Цахим үйлчилгээний нэгдсэн системийн Операторын орон тоог 8 сум баталж 5 сум нь хавсарган гүйцэтгэгчээр урамшуулал олгож иргэдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. Операторын урамшууллыг хавсарган гүйцэтгэгчээр олгож буй 5 суманд 2022 онд орон тоог баталж цалинжуулах чиглэл өгөгдсөн.	100
77		9.. “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажилтнуудыг шаардлагатай сургалт, дадлагад хамруулах талаар зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ““Нэг цонхны үйлчилгээ”-ний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 153 дугаар тогтоол, ““Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 141 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.	12 төрийн байгууллагын 76 үйлчилгээг цахимжуулж e-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн системд нэгтгэх ажлыг зохион байгуулж дахин загварчлах, шийдвэрлэх эрх үүсгэх, системийн тохируулга хийх сургалтыг 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 03-ны өдрийн хооронд танхимаар зохион байгуулж 13 сумын оператор бүрэн хамрагдсан.	100
78	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг	2.. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дэргэд өөрийн санхүүжилтээр цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжиж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Одоогоор хувийн хэвшлийн цэцэрлэг ажлуулах санал санаачлаг ирээгүй байна.	100

79	нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-05-01 Дугаар 2019_183	3.. Салбар бүлэг болон зуны цэцэрлэг ажиллуулах мэргэжлийн багш, хүний нөөцийг бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Наран, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Дарьганга сумдад 6 гэр бүлэг ажиллуулж байна. Хувилбарт болон зуны сургалтыг хичээллүүлэхээр төлөвлөсөн хэдий ч цар тахалтай холбоотой хорио цээр тогтоосны улмаас явагдах боломжгүй болсон. 2020-2021 оны хичээлийн жилд 1447 таван настай хүүхэд байгаагаас 1437 буюу 99,2 хувь нь СӨБ-д хамрагдаад байна. Цэцэрлэгийн үндсэн бүлэгт хамрагдах боломжгүй алслагдсан хөдөөгийн 5 настай 49 хүүхдэд хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж гэр бүлийн орчинд хөгжлийн дэмжих ном тоглоомын багцаар үйлчилж хөгжлийг дэмжиж байна.	100
80		4.. Шинээр барих орон сууцны хорооллын барилгын ажлын холбогдох зөвшөөрлийг олгохдоо сургууль, цэцэрлэгийн хамт төлөвлөн барих талаарх барилгын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг мөрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Одоогоор томоохон хороолол барих зөвшөөрөл олгоогүй байна. Аймгийн хэмжээнд 2015-2016 онд Эрдэнэцагаан, Баруун-Урт, Дарьганга сум хот байгуулалтын тухай хуулийн дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. 2021 онд Мөнххаан, Сүхбаатар, Халзан сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж байна. Аймгийн төв Баруун-урт суманд хийгдсэн 2030 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөгөөр 3 цэцэрлэг, 2 сургууль төлөвлөснөөс улсын төсвийн хөрөнгөөр 1 цэцэрлэг, 1 сургууль баригдаж ашиглалтад орсон. Хөгжлийн төлөвлөгөөнд тухайн сумын хүн амын тоог харгалзан сургууль, цэцэрлэг, дотуур байрыг төлөвлөн улсын төсвөөр шинээр барих, орон нутгийн төсвөөр засварлах ажлууд төлөвлөлтийн дагуу хийгдэж байна. Аймгийн төвд шинэ суурьшлын бүс болох Боловсрол хорооллыг 2015 онд ашиглалтад оруулж шинэ цэцэрлэг, нэгдсэн дотуур байрыг ашиглалтад оруулж 960 хүүхдийн сургуулийг улсын төсвийн хөрөнгөөр барьж байна.	100
81	Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай 2019-05-01 Дугаар 2019_185	4.. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасны дагуу дээрх ажлыг хийхээр төлөвлөж байсан ч Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар уг татварын хэмжээг 2021 оны долоодугаар сарын 01 өдрийг хүртэл “0” хувиар тогтоох буюу чөлөөлөх чиглэлийг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ-т зөвлөмж болгосон Засгийн газрын	70

		хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	тэмдэглэл гарсантай холбоотойгоор хаврын ажил хийгдээгүй. Халзан сум бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтантай байгаль орчинд халгүй энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.0 мян/га талбайд зохион байгуулж, бэлчээрт 25 шувууны үүрийг босгосон. Аймгийн хэмжээнд үлийн цагаан оготоны тандалт судалгаа хийхэд 190 мян/га талбайд тархалттай 91 мян/га талбайд голомтлон тархсан судалгаа гарсан.	
82	Жагсаалт батлах тухай 2019-05-12 Дугаар 2019_190	3.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг баримтлан хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг баримтлан Зүүн бүс, орон нутгийн хүн амын эрэлт, хэрэгцээ, эдийн засгийн ач холбогдолд үндэслэн төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилан “Сүхбаатар аймагт 2021-2024 онд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл”-ийг /Аймгийн Засаг даргын 2021 оны 05 сарын 21-ны өдрийн А/308 дугаар/ захирамжаар баталгаажуулж, олон нийтэд зарлаж, төсөл хэрэгжүүлэх хувийн хэвшлийн төлөөллүүдийн санал санаачлалыг дэмжин ажиллаж байна. Зүүн бүсийн хэмжээнд хөгжүүлэх тэргүүлэх салбарын үйлдвэрүүдээс Баруун-Урт сумын 05-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Дөрвөн гэгээн эрдэнэ” ХХК-д сард 200 тонн ноос угаах үйлдвэрийн газрын асуудлыг шийдвэрлэж, тус үйлдвэрийн ТЭЗҮ-г Азийн хөгжлийн банкны санхүүжилт бүхий “Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог” дэмжих нь төслийн хүрээнд үнэ төлбөргүй боловсруулан аж ахуй нэгжид хүлээлгэн өгсөн бөгөөд 2021 онд үйлдвэрийн барилгын ажил бүрэн баригдсан байна.	100
83	Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-12-25 Дугаар 2019_474	4.. Инженерийн дэд бүтэцтэй болон төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой хот, суурин газарт унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр худаг гаргаж, ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт олгохыг хязгаарлах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2022 онд ажлын хэсэг байгуулагдахаар төлөвлөн ажиллаж байна.	30

84		5.. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан хот, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж болон цэвэрлэх байгууламж, төвлөрсөн дулаан хангамжийн систем, нийтийн халуун усны төв бий болгоход шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжид нэн тэргүүнд хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Иргэдийг ус, дулаан хангамж, ариутгах татуурга, хэрэглээний халуун ус, нийтийн халуун усаар үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлэхээр УДДТ үүдэнд цахилгаан бойлер суурилуулах, шинээр нийтийн халуун ус барихаар зургийн даалгавар боловсруулан аймгийн ЗДТГ-т хүргүүлэн худалдан авах ажиллагааг явуулахаар бэлтгэл ажил хангадан ажиллаж байна. Мөн АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй Цэвэрлэх байгууламжийн угсралтын хүрээнд худалдааны гудамжин, аж ахуйн нэгж байгууллагуудыг нэгдсэн ус хангамж, ариутгах татуургын системд холбон ажиллаж байна.	70
85	Үндэсний жагсаалт батлах тухай 2019-12-25 Дугаар 2019_475	2.. Дээрх жагсаалтад орсон өвлөн уламжлагчид батламж олгох, алдаршуулах, урамшуулах, шавь сургалт зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх зохих арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2021 онд Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд 15 өвийн 45 өвлөн уламжлагчийг нэмж бүртгэж, нийт 298 өвлөн уламжлагч бүртгэгдсэн. Дарьганга сумын өв тээгч Давхайн Дугарсүрэнгийн баримтат нэвтрүүлэг хийж, Эрдэнэцагаан сумын өв тээгчийн Уул усны домог, түүхийн тухай ярилцлагыг угсаатны зүйн музейгээс эрхлэн гаргадаг сэтгүүлд хэвлүүлсэн. Музейн сан хөмрөгийг баяжуулах, өв тээгчийн үйл ажиллагааг дэмжих, өвлүүлэх, алдаршуулах ажлын хүрээнд өв тээгчээр дарьганга эмээл, ташуур, хазаар, хударга, хөмөлдөргийг иж бүрнээр хийлгэж байна. 5 сум өв тээгчдийг алдаршуулах, тэдний үйл хэргийг залгамжлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг цар тахалтай холбоотойгоор цахимаар хийж олон нийтэд хүргэсэн. “Соёлын биет бус өв тээгчдийг цахим орчинд сурталчлан алдаршуулъя” аяны удирдамжийн дагуу нутгийн домог, хууч яриа ярих чөллөж цахимаар зохион байгуулж, сумдын 5 өвлөн уламжлагчийн 9 домог ярианы бичлэгийг цахимаар олон нийтэд хүргэж, 3516 хүн үзэж сонирхсон.	100
86	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-01-08 Дугаар 2020_10	3.. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжийн үнэлгээ, төсвийн зардал, чанар байдлыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд залруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцохыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэгж хүчин чадлын жишиг үнэ, метр квадрат, уртааш метр болон хэмжээ талбай зөрүүтэй үнэлэгдсэн хөрөнгийн залруулга хийх, мөн Баруун-Урт сумын ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны 05 тоот тогтоолоор баталсан газрын төлбөрийн бүсчлэл, зэрэглэлтэй тулган баталгаажуулж зөрүүтэй тохиолдолд залруулга хийхийг байгууллагын дарга нарт зөвшөөрсөн тогтоолыг гарган	100

			байгууллагуудад хүргүүлэн арга хэмжээг авсан. Үйл ажиллагаа хэрэгжсэн тул хасах саналтай байна.	
87		9.. Ард иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор төрийн өмчийн хөрөнгөөр тохижуулсан нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний доорх газрыг холбогдох төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр бүртгэх асуудлыг судлан танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т тус тус даалгасугай.	2021 онд цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбайн зориулалтаар 85534м2 газрыг Сүхбаатар аймгийн биеийн тамир спортын газрын нэр дээр бүртгэн баталгаажуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгоод байна. Мөн Уртын голын цэцэрлэгт хүрээнг “Уртын гэгээ” ОНӨААТҮГ-т нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбайн зориулалтаар аймгийн Засаг даргын захирамжаар 397820 м2 газрыг эзэмшүүлж газрын кадастрын мэдээллийн системд бүртгэн баталгаажуулж гэрээ гэрчилгээг олгосон байна.	100
88	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 2020-01-08 Дугаар 2020_9	4.. Орон нутгийн өмчийн үзлэг, тооллого явуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолоор нэмэлт оруулж, 2022 оны төсөвт 15,0 сая төгрөгийг тусган батлуулсан.	100
89	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_18	2.. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эд, бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, хүчин чадлаас давсан нөөцийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжих, түүхий эдийг үнэгүйдэхээс хамгаалах бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Баруун-Урт сумын "Дарьт шүтээн" ХХК-ний "Баян тал" махны үйлдвэр нь мах боловсруулах үйлдвэрийн чанар, стандартыг бүрэн хангаж ИРАН улсад 300-500 тн хонь, ямааны мах экспортлохоор "ИНТЕРНЕЙШЛ ХАЛАЛ МИЙТ КОМПЛЕКС МОНГОЛИА" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж 2021 онд 80 тн махыг экспортод гаргаад байна.	100
90		4.. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Баруун-Урт суманд сард 200 тонн ноос угаах үйлдвэр 2022 онд ашиглалтанд орох гэж байгаатай холбогдуулан сум бүрд хоршоодоор дамжуулан ноос хүлээн авах цэг байгуулах газрын асуудлыг 2022 оны аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд оруулан батлаад байна. Мөн малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Ашид баян мөнх” хоршоо 114.0 сая, Баруун-Урт сумын “Мөнгөн саам” хоршоо хадлан, ногоон тэжээлийн үйлдвэрлэлийн чиглэлээр 60.0 сая төгрөгийн жилийн 5 хувийн хүүтэй	100

			хөнгөлөлттэй зээлийг жижиг дунд үйлдвэрийн газраас авсан байна. Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Уулбаян сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах мах нядалгааны цехтэй болсон.	
91	Жагсаалт батлах тухай 2020-01-22 Дугаар 2020_21	3.. Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай.	Сүхбаатар аймгийн 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2020 оны 12-р сарын 24-нд аймгийн Засаг даргын А/684 дүгээр захирамжаар баталсан нийтдээ 5 удаа шинэчлэн батлагдсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 81 нэр, төрлийн 13,266,018,846 /Арван гурван тэрбум зургаан зуун ерөн сая арван найман мянга найман зуун дөчин/ төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер, Улсын төсвийн хөрөнгөөр 9 нэр, төрлийн 13,589,300.0 /Арван гурван тэрбум нэг зуун тавин зургаан сая гурван зуун мянган/ төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер, Нийт 90 нэр, төрлийн 26,855,318.846 /Хорин зургаан тэрбум найман зуун тавин таван сая гурван зуун арван найман мянга найман зуун дөчин зургаан/ төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлахаар төлөвлөснөөс 85 нэр төрлийн 26,754,318,846 /Хорин зургаан тэрбум долоон тавин дөрвөн сая гурван зуун арван найман мянга найман зуун дөчин зургаан/ төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлаж, 101,000,000 төгрөгийн 5 нэр төрлийн тендер зарлаагүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт нь 94,4 хувьтай байна. Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр давхацсан тоогоор 105 удаа тендерийг зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж бүрэн нийтэлсэн.	100
92		4.. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар,	2021 онд 77 үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж давхацсан тоогоор 380 гишүүн ажилласан бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг бөглүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан.	100

		аймаг нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.		
93		5.. Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид 14 хоног тутамд хүргүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Улсын төсвөөс 9 нэр төрлийн төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн байна. Сангийн яамны publicinvestment.gov.mn сайтад худалдан авах ажиллагаа, гэрээ, гүйцэтгэлийн мэдээллийг сар бүр оруулж ажилласан.	100
94	Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай 2020-03-18 Дугаар 2020_95	3. Тэргүүлэх чиглэлд тусгагдсан инновацийн үйл ажиллагааны арга хэмжээг өөрсдийн үйл ажиллагааны жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, тухайн арга хэмжээнд батлагдсан төсөвт эх үүсвэрийн дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн дагуу аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2021-2025 оны үндсэн чиглэлд өөрийн орон нутгийн онцлогт тохируулан 4 чиглэлээр зорилт дэвшүүлэн төлөвлөөд байна. Тус бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд жилийн Дижитал технологид суурилсан контент, соёлын үйлчилгээ хүрээнд "Дарьганга соёлын өв" брэнд брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контент бүтээх,олон нийтэд сурталчлах, сувгийн хөгжүүлэлт хийх, Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг орон нутаг, улс, олон улсын түвшинд сурталчлан таниулах зорилготой цахим каталогийг ашиглалтад оруулах, Хиймэл оюун хөгжүүлэх, хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр ЕБС-д лабораторийн байгуулж виртуал орчин бүрдүүлэн, дижитал технологи ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг ажил арга хэмжээг төлөвлөн үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.	100

95	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106	1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний талаар хөмрөг үүсгэгч Эрдэнэцагаан сумын Чоногол ОНӨҮГ, Баяндэлгэр сумын ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, Орон нутгийн өмчийн алба, Баруун-Урт сумын Хүүхдийн 3-р цэцэрлэг, Онцгой байдлын газар, Түмэнцогтын сумын Улсын нөөцийн салбар, Түмэнцогт ОНӨҮГ, Асгат сумын Эрүүл мэндийн төв зэрэг 20 байгууллагын бичиг хэргүүдэд нөхөн бүрдүүлэлт, цахим сан үүсгэх талаар ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах, Мөн Архивын ерөнхий газраас зохион байгуулсан 5 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 154 албан хаагч хамрагдсан. Албан хэрэг хөтлөлтийн талаарх анхаарах асуудал сэдвээр Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэстэй хамтран Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат, Дарьганга, Наран, Онгон сумдад зөвлөн туслах болон “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль болон журмыг шинээр таниулах” сургалтыг зохион байгууллаа. Нийт давхардсан тоогоор 265 төрийн албан хаагч хамрагдсан. Архивын ерөнхий газраас жил болгон зохион байгуулдаг анхан шатны болон мэргэшүүлэх сургалтад Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Прокурорын газар, Мал эмнэлэг зэрэг байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтнууд суусан бөгөөд “Төрийн албаны болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэглээний талаар сургагч багш бэлтгэх” сургалтад архивын тасгийн дарга, Сан хөмрөгч тус тус хамрагдсан.	100
96		2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй сум, албан байгууллагууд тухайн оны төсөвт архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Онцгой байдлын газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүү хяналт, аудитын хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар шинээр зориулалтын нягтруулсан шүүгээ болон скайнер тоног төхөөрөмж худалдан авсан.	100

97	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2020-03-25 Дугаар 2020_110	2. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Б.Баасандорж), аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Чөлөөт бүсийн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. тухайн жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд олон нийтийн саналыг авах, төлөвлөх болон батлагдсан төлөвлөгөөг мэдээлэх, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох асуудлыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан шийдвэрлэх; 2.2. газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэр, холбогдох мэдээллийг газрын кадастрын улсын мэдээллийн санд тусгах болон улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд бүртгэх ажлыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан гүйцэтгэх.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх МУЗГ-ын 110 дугаар тогтоолын хэрэгжүүлэх зорилгоор Газрын удирдлагын нэгдсэн системийн газрын кадастрын систем, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн систем, газрын мониторингийн систем, хаягийн мэдээллийн систем, газрын үнэлгээний систем гэсэн 5 системээр дамжуулан орон нутагт газрын харилцааны үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 онд Бүх сумдын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем дээр төлөвлөгөөний төслийг боловсруулж, сумдын ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэл ажил ханган ажиллаж байна. 2021 оны 09 дүгээр сарын 29-нд Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хурлыг хуралдуулж “2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоох тухай” 01 дугаар тогтоолоор 2022 онд 13 сумын хэмжээнд өмчлүүлэх газрын төлөвлөгөө болон батлуулаад байна. Аймгийн хэмжээнд өмчлөлийн 1156 иргэний 106.2 га газар өмчлүүлэхээр төлөвлөөд байна. Аймгийн хэмжээнд хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж газрын даргын тушаалаар ажил эрчимжүүлэх тушаал гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллаж газрын даргын 1/52 дугаар албан бичгээр бүх сумдын даамлуудыг дуудан 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийг дуустал бүх сумдын газрын даамлуудыг 2 хэсэгт хуваан хаягийн мэдээллийн нэгдсэн систем дээр ажиллах сургалтыг гардан зохион байгуулж, бүх сумдын хаягийн системийн засвар өөрчлөлт, шинэчлэлтийн ажлыг үр дүнтэй гүйцэтгэж газрын даргын 1/65 дугаар албан бичгээр ГЗБГЗЗГ-т ажлын тайланг хүргүүлээ. Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн системийн хаягжуулалтын ажлын явц хянасан нэгж талбар 95.2%-тай, хянасан барилга 94.2%-тай гүйцэтгэсэн байна. Газрын удирдлагын нэгдсэн системээр дамжуулан газрын харилцааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр бүх сумын Засаг дарга, газрын даамлууд, удирдлагуудад газрын даргын албан бичгээр чиглэл хүргүүлэн ажиллаж байна.	100
----	--	--	--	-----

98		4. Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу болон бичил уурхай эрхлэх зориулалтаар ашиглах талбайн мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Бичил уурхай эрхлэгч бүртгэлтэй нөхөрлөл, хоршоо байхгүй.	100
99		7. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд бүх талын оролцоо дэмжлэг үзүүлж, зохих мэдээ, мэдээлэл хүргүүлэн ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах чиглэлээр 13 сумын газрын даамалд мэргэжил аргазүйн зөвөлгөөг дотоод чат болон утсаар мөн даамлуудын компьютерт хандан мэргэжлийн зөвөлгөө мэдээллээр өдөр тутамдаа ханган ажиллаж байна. Мөн газрын даргын албан бичгүүдээр дээд газраас ирсэн чиглэлийг хүргүүлэн ажиллаж байна. Газар зохион байгуулалт төлөвлөлтийн цахим системд тусгагдсан сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэд олон нийтэд хүргэхээр Байгууллагын facebook page хуудсаар болон egazar.gov.mn сайтаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.	100
100	Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2020-04-15 Дугаар 2020_138	2. Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн үйлдвэрлэл хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаргын болон газрын доорх усыг ашиглах боломжтой байршилд шинээр тариалангийн газар эзэмшүүлэх, ашиглаж байгаа тариалангийн талбай хоорондын зайд тэлэлт хийж өргөтгөх, тариалан эрхлэх газарт иргэдэд зөвхөн хүнсний ногоо тарих зориулалтаар талбай олгох, цаашид зориулалтыг өөрчлөхгүйгээр тариалах талбайг нэмэгдүүлэх боломжийг судалж, хууль, журмын хүрээнд зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Сүхбаатар сум шинээр 25 га-д төмс, хүнсний ногоо тариалах дуудлага худалдаа зарлагдаж 15га, Баруун-Урт сум шинээр 5.5 га талбайг төмс, хүнсний ногоо тариалахаар дуудлага худалдаа зарлаж 3.5га нийт 18.5га талбайг 20 иргэнд шинээр эзэмшүүлсэн. Орон нутгийн жимс, жимсгэний үржүүлгийн төвд үхрийн нүд 50, алим 50, чавга 50, интоор 50 ширхгийг тус тус тариалж, 2.3 сая төгрөгөөр 0.4 га талбайн услалтын системийг Хөдөө аж ахуйн дэмжих сангаас худалдан суурилуулсан.	100
101	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах	1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай.	2020 оны байдлаар хэмжүүрээр тооцоо хийдэг 9-н аж ахуй нэгж байгууллага байна. Үүнээс төсөвт байгууллага 1, аж ахуй нэгж 8 байна. Цаашид тоолуур суурилуулж болох төсвийн 40 албан байгууллага байна. Ковид-19 цар тахлын улмаас хийгдсэн ажил, арга хэмжээ байхгүй	30

102	тухай 2020-04-22 Дугаар 2020_144	3. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулах барилга байгууламжид дулааны эрчим хүчний тоолуур суурилуулсан байх шаардлагыг холбогдох дүрэм журамд тусгайлан зааж мөрдүүлэх, цаашид цахилгаан, дулааны эрчим хүчний бодит өртөг, зардалд суурилсан үнэ тарифыг тогтоож мөрдүүлэх, дулааны эрчим хүчний хөндлөн татаасыг зогсоох, нэгжийг тэгшитгэх, дулааны эрчим хүчний хэрэглээг зөвхөн тоолуураар тооцдог байх асуудлыг судлан холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт болон Эрчим хүчний зохицуулах хороо (А.Тлейхан)-нд тус тус үүрэг болгосугай.	Сүхбаатар аймгийн Нийтийн аж ахуйн байгууллага “Дөрвөлж” /ОНӨ/ ХХК нь төлөвлөгөөт их болон урсгал засварын ажлыг батлагдсан засвар үйлчилгээг графикийн дагуу хийж гүйцэтгэж байна. Орон нутгийн төсөв-2.0 тэрбум, Үүнд: Усан халаалтын зуух-14ш, шинээр шугам сүлжээ өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмж шинэчлэх, өргөтгөх, засвар хийх, барилга байгууламж өргөтгөх, шинэчлэх ажлууд хийгдэж байна.	70
103	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020-05-06 Дугаар 2020_163	3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.	Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.	100
104	Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-05-13 Дугаар 2020_178	4. Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зарим суманд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоо байгуулж, кластерын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Баруун-Урт суманд сард 200 тонн ноос угаах үйлдвэр 2022 онд ашиглалтад орох гэж байгаатай холбогдуулан тус үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор сум бүрд хоршоодоор дамжуулан ноос хүлээн авах цэг байгуулах газрын асуудлыг 2022 оны аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд оруулан батлаад байна. 2022 онд “Хоршоог хөгжүүлэх сан” үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан сангийн журмын төсөлд хоршоодыг кластерын тогтолцоогоор хөгжүүлэх санал хүргүүлэн ажилласан. Сангийн журам батлагдах үеэр малчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хоршиж үйл ажиллагаа эрхлэхийн ач холбогдол болон энэ талаарх төрийн бодлогыг сурталчлах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Мөнххаан, Онгон, Уулбаян, Сүхбаатар мал аж	100

			ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах хоршоо байгуулагдан ажиллаж байна.	
105	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2020-08-05 Дугаар 2020_37	3. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	МУ-ын Засгийн газрын 2020 оны 213 дугаар тогтоолын хүрээнд Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулдаг Цайрт Минирал ХХК-ны гүүрний барилга угсралтын ажил хийхээр БНХАУ-ын 52 иргэнийг 7 хоног тусгаарлан ажилах байранд байршуулан, үзлэг шинжилгээнд хамруулан, зөвшөөрлийг олгон ажиллалаа. 2022 онд ажиллуулах 46 гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дэмжих санал олгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан.	100
106	Төв, суурин газрын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2020-08-25 Дугаар 2020_69	4. Монгол Улсын Зэвсэгт хүчний анги, салбарууд болон боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж дуусгах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Соёлын сайд С.Чулуун, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Улсын төсвийн 35.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уулбаян сумын ЭМТ-н больницын барилгын уурын зуухны тогоо, янданг шинэчилж ашиглалтад хүлээн авсан. Байгууллагуудын урсгал засварын зардлаар барилгын урсгал болон автомашины засвар үйлчилгээг хийж өвөлжилтийн бэлтгэл ханган ажиллаж байна. Орон нутгийн 39.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уламжлалтын эмнэлэгт автомашин, Сүхбаатар сумын Эрүүл мэнд, боловсролын сангийн 119.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭМТ-д туулах чадвар сайтай Ниссан фатроль автомашин, Баяндэлгэр сумын ард иргэдийн 29.0 сая төгрөгийн хандив тусламжаар ЭМТ-д приус 20 автомашины парк шинэчлэлт хийгдэж өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Нүүрс түлээний 1-3 сарын нөөцтэй. Түргэн тусламжийн дуудлагын машин бүрд хувийн бэлтгэл /20л шатахуун, дахь дэгтий тус бүр 2 ш, галын хор, хүрз, татлага/ хангуулаад байна	100
107		5. Аймаг, нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын системд их болон урсгал засвар, туршилт тохируулгын ажил хийлгэж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Сүхбаатар аймгийн Нийтийн аж ахуйн байгууллага “Дөрвөлж” /ОНӨ/ ХХК нь төлөвлөгөөт их болон урсгал засварын ажлыг батлагдсан засвар үйлчилгээг графикайн дагуу хийж гүйцэтгэж байна. Орон нутгийн төсөв-2.0 тэрбум, Үүнд: Усан халаалтын зуух-14ш, шинээр шугам сүлжээ өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмж шинэчлэх, өргөтгөх, засвар хийх, барилга байгууламж өргөтгөх, шинэчлэх ажлууд хийгдэж байна.	100

			Төв, суурин газрын оршин суугчдад зориулсан гэр, амины орон сууцны байшингийн дулааны алдагдлыг бууруулах, ажлын хүрээнд аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар дээр аймгийн хэмжээний төсвийн байгууллагуудын барилга байгууламж, ашиглалтын нэгдсэн судалгаа хийж хуучин орон сууцуудад засвар үйлчилгээ хийсэн	
108		15. Цаг агаарын аюултай, гамшигт үзэгдлийн урьдчилан сэргийлэх мэдээг олон нийтэд шуурхай дамжуулж хүргэх ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэлд, төв, суурин газрын оршин суугчдад зориулсан гэр, амины орон сууцны байшингийн дулааны алдагдлыг бууруулах, сайжруулсан түлшний хэрэглээний талаар урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттай зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т тус тус даалгасугай.	Онцгой байдлын ерөнхий газар болон Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс ирсэн урьдчилан сэргийлэх, цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг SMS SENDER IRS праграмм скайтелийн 3G модемийг ашиглан цаг алдалгүй АОК гишүүд болон, сумдын тамгын газрын дарга нар, хөдөөний багуудын малчин өрхүүдэд багц мессэжийн үйлчилгээг ашиглан 12 удаа 13 сумын 35120 хүнд цаг алдалгүй түргэн шуурхай хүргэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.	100
109	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-11-18 Дугаар 2020_183	18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	2021 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа ажил үйлчилгээ хийж гүйцэтгэсэн аж ахуй нэгжүүдийн төлбөрийг 100 хувь тухай бүр барагдуулж ажилласан нийтдээ 17,9 тэрбум төгрөг олгосон байна. Ковид 19 цар тахалтай холбоотой хөрөнгө оруулалтын төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт удааширсан, хугацаандаа ашиглалтанд орж чадахгүй нөхцөл байдал үүсч гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах ажлууд хийгдсэн.	100
110		19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	2021 онд Дотоодын үйлдвэрлэл эрхлэгч иргэн ААН-ээс аймгийн хэмжээнд мах, сүү гэх мэт 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний 547.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 40 гаруй төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтаас 10 тендерт орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч 1,357,299,019 төгрөгний гэрээ байгуулсан нь орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оноос 17.5-иар өссөн.	100

111		23. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, соён гэгээрүүлж, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх нэвтрүүлэг, контентыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах, нэвтрүүлэх, хүн хооронд 2 метрийн зай барих, амны хаалт тогтмол зүүлгэх, үйлчлүүлэгч, ажилчдын биеийн халууныг тогтмол үзэх, ариутгах бодисыг байршуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр тутам хийх ажлыг зохион байгуулж байхыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Соёлын сайд С.Чулуун, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян) болон холбогдох бусад албан тушаалтанд даалгасугай.	"Ковидын эргэн тойронд" цуврал шууд нэвтрүүлгийг орон нутгийн BBS телевизтэй хамтран 8-н дугаар бэлтгэж үзэгчдэд хүргэв. Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл, Боловсролын байгууллагын төлөөлөл Шуурхай штабын удирдлага оролцож мэдээлэл өгч ажиллав. Аймгийн Онцгой комисс, Шуурхай штабын хурлаас гарсан шийдвэрийг Шуурхайн штабын хэвлэл мэдээллийн ажилтан хариуцаж мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар дамжуулан хүргэж байна. Коронавируст халдвар /ковид-19/- өөс урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах, иргэдэд зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор орон нутгийн BBS телевизээр Даваа, Лхагва, Баасан гарагийг өдөр 12.00 цагт өдөр бүр халдварын тархалт нөхцөл байдлын мэдээллийг бэлтгэж шууд лайваар болон эфирээр халдвар гарснаас хойш 1500 орчим цагийн эфирийн мэдээллийг бэлтгэн хүргэсэн. Халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмжийг цахимд байршуулж мэдээлэл түгээх ажлыг тогтмол шинэчлэн хийж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, постерыг тогтмол байршуулж цахимаар мэдээллийг хүргэж ажилладаг. Хоногт бүртгэгдэж буй халдвар болон Коронавируст халдвар /Ковид-19/ өөс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх бодлого шийдвэр нэмэлт тунгийн дархлаажуулалтын талаар долоо хоног бүрийн Лхагва гарагт ЭМГ-аас зөвлөгөө мэдээллийг бэлтгэж орон нутгийн "BBS" телевиз, "SB info" сайт, "Сүхбаатарын өнгө" сонинд болон Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын пэйж хуудсаар дамжуулан тогтмол мэдээ, мэдээллийг хүргэж байна. BBS телевиз, SB info, Сүхбаатарын өнгө сонинд нийтдээ 2000 орчим мэдээллийг бэлтгэж нийлүүлсэн.	100
112	Жагсаалт батлах тухай 2020-12-16 Дугаар 2020_215	4. Жагсаалтад багтсан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахин мөрдөх, шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн бүсийг хамгаалалтад авч, ажилчид түр байршин ажиллах нөхцөлийг бүрдүүлэх замаар тасалдалгүй үйл ажиллагаа явуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сүхбаатар аймгийн хэмжээнд мал төхөөрөх 7, мах боловсруулах 3 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Тогтмол үйл ажиллагаатай мал төхөөрөх 6 аж ахуйн нэгж байна. Мах боловсруулах үйлдвэрлэлийн стандарт шаардлагыг хангаж, гадаадад мах экспортлох хүсэлт гаргасан Дөрвөн гэгээн эрдэнэ хоршоо, Дарьт шүтээн ХХК-дад МХЕГазар, МЭЕГазар, ХХААЯ-ны ажлын хэсэгтэй хамтран зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн	100

			цаашид стандарт шаардлага хангаж ажиллахад анхаарах асуудлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. МХГ-аас "Дөрвөн гэгээн эрдэнэ" хоршоо мах боловсруулах үйлдвэрлэлийн зэрэглэлийг хангасан тул хамтарсан дүгнэлт гаргаад байна.	
113	Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-12-23 Дугаар 2020_235	4. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан шийдвэрлэж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Баруун-Урт сумын 11 дүгээр цэцэрлэг хүүхэд бүрийн оношид тохируулан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажилласан ба ЕБ-ын 1-р сургуулийн багш нартай ганцаарчилсан хөтөлбөр боловсруулах, ХБХ-тэй ажиллах чиглэлээр туршлага солилцон хамтран ажилласан. 2021 оны 05 сард Боловсрол шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй бага ангийн багш нарыг чадавхжуулах сургалтанд 14 бага ангийн багш хамрагдсан бөгөөд 2021 оны 09 сарын 20-24 ний өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтанд 14 багш бага ангийн багш давтан сургалтанд хамрагдсан бөгөөд нэмэлтээр 10 багш сургалтанд хамрагдсан байна.	100
114		6. Бүх шатны сургалтын байгууллагын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан зохих стандартад нийцүүлсэн зам, талбайтай болгох арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан налуу шат нийт сургуулийн 56.4%, цэцэрлэгийн 41.7% -д, ариун цэврийн өрөө нийт сургууль, цэцэрлэгийн 17.5% -д байдаг. Баруун-Урт сумын 11-р цэцэрлэг нь тусгай хэрэгцээ шаардлагатай холимог бүлэгтэй /хөгжлийн бэрхшээлтэй/ бөгөөд АЦБ, коридорын хана зэргийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан стандартын дагуу тохижуулсан. ПИН олон улын байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, БШУЯ-тай хамтарсан багийн төсөл хөтөлбөрт хамрагдан “1,200,000 төгрөгийн ваучер”-ийн тусламж үйлчилгээг баруун-Урт сумын 11-р цэцэрлэгийн тусгай бүлгийн 11 хүүхэд болон тус цэцэрлэгийн хувилбарт сургалтад хамрагддаг хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдэд хүргэсэн. БШУЯ-ны Тусгай хэрэгцээт боловсролын хэлтсээс зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төсөлд хамрагдан 500,0 төгрөгийн хичээлийн хэрэгслээр хангасан. Мөн суралцагчдын хөгжлийг дэмжих зорилгоор 1.000.000₮-ний хөрөнгөөр зогсоогч аппарат болон бусад техник хэрэгслээр хангагдсан.	70

			Дэлхийн банкны санхүүжилтээр БШУЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд лаборатори 1 дүгээр сургуульд 33,1 сая төгрөгийн санхүүжилттэй “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-ыг байгуулж, 8 багш ажилтан чадавхжуулах сургалтад хамрагдан түгээн дэлгэрүүлэх сургалтыг 2 удаа 82 багшид сургалтанд хамрагдаж, 17 ХБХ суралцагчдад үйлчилгээгээ хүргэж байна.	
115	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-12-30 Дугаар 2020_253	3. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын дүнд хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх; 1.2. Монгол Улсад короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа 2020 онд хэрэгжиж дуусах боловч батлагдсан санхүүжилтийг бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, мөн бусад салбарын зайлшгүй шаардлагатай болон Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 2020 оны үлдэгдэл санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах. 2. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 3. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.	Ковид-19 өвчлөлийн үед ЭМСалбарын батлагдсан төсөвт хязгаарлалт хийгдээгүй 100 хувь санхүүжсэн. Энэ онд дутуу санхүүжсэн хөрөнгө оруулалтын ажил байхгүй ба 2020 онд Дарьганга, Наран сумдын шинэ барилгын ажил графикийн дагуу 100 хувь санхүүжигдэж энэ онд ашиглалтад орсон.	100
116	Жагсаалт батлах тухай	3. “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх	2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 90 нэр төрлийн төсөл арга хэмжээ тусгагдсан. Мөн улсын	100

	2021-01-15 Дугаар 2021_15	төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт, "Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг урьд нь байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	төсвөөс 9 нэр төрлийн төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн байна. Үүнээс харъяа байгууллагууд руу 22 нэр төрлийн бараа ажил үйлчилгээ эрх шилжүүлсэн байна. Мөн Засгийн газрын тогтоолын дагуу 2 нэр төрлийн барааны тендер, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын 2021 оны 03 сарын 05-ны өдрийн 1/581 тоот албан бичгийн дагуу 13 барааны тендер тус тус хүчингүй болсон. Нийт 90 нэр төрлийн бараа ажил үйлчилгээ байна. 86 төсөл арга хэмжээ зарлагдаж, гүйцэтгэл 95,5%-тай байна. Тайлант хугацаанд нийт зарлагдсан 86 нэр төрлийн бараа ажил үйлчилгээний 8 нь ШХА байсан. Үлдсэн 78 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг цахимаар зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.	
117	Төлөвлөгөө батлах тухай 2021-01-20 Дугаар 2021_18	2. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн жил бүрийн холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	2021-2022 оны хичээлийн жилд 1-5 ангийн 231 бүлгийн 7236 сурагчдыг "Үдийн хоол" хөтөлбөрт 100 хамруулж байна. Сургууль, цэцэрлэгүүдэд эх орныхоо хөрсөнд ургасан хүнс хүнсний ногоо түлхүү хэрэглэх, дотоодын хүнсний бүтээгдэхүүнийг авч ашиглахыг зөвлөдөг. Сургууль цэцэрлэгийн 80.0% нь өөрийн хүлэмжид тарьсан хүнсний ногоог хүнсэндээ хэрэглэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" болгох ажлын хүрээнд БШУЯ-наас сургууль, цэцэрлэг, дотуур байрын хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажилчдад зохион байгуулсан цахим сургалтад эмч – 14, нярав – 39, тогооч – 97, БСУГ –ын мэргэжилтэн -2, нийт 152 ажилтан албан хаагчид хамрагдаж, хоолны технологийн карт боловсруулах, хоолны илчлэг тооцох, хүүхдэд зориулсан зууш, салат, хүйтэн сүмс бэлтгэх, үндсэн болон шөлтэй хоол хийх, нарийн боов бэлтгэх арга технологид суралцлаа. Сургууль, цэцэрлэгүүд өөрсдийн хөрөнгөөр болон эцэг эхийн дэмжлэгээр ус уух нөхцөлийг бүрдүүлж анги бүрт баллонтой цэвэр усыг хэрэглэж байна. Мөн Баруун-Урт сумын тамгын газраас төвийн 11 цэцэрлэгийг ус шүүх цэвэршүүлэгчээр хангасан	100
118	Түр хороо байгуулах тухай 2021-02-10 Дугаар 2021_29	4. Түр хороо, Ажлын шуурхай хэсгийг үнэн зөв, бодит мэдээллээр тухай бүр хангаж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх, нийтэд буруу ташаа, үндэслэлгүй	Аймгийн Онцгой комисс, Шуурхай штабын хурлаас гарсан шийдвэрийг Шуурхайн штабын хэвлэл мэдээллийн ажилтан хариуцаж мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар дамжуулан хүргэж байна.	100

		мэдээ, мэдээлэл тараахгүй байх, тараасан бол холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Коронавируст халдвар /ковид-19/- өөс урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах, иргэдэд зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор орон нутгийн BBS телевизээр Даваа, Лхагва, Баасан гарагийг өдөр 12.00 цагт өдөр бүр халдварын тархалт нөхцөл байдлын мэдээллийг бэлтгэж шууд лайваар болон эфирээр халдвар гарснаас хойш 1500 орчим цагийн эфирийн мэдээллийг бэлтгэн хүргэсэн. Халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмжийг цахимд байршуулж мэдээлэл түгээх ажлыг тогтмол шинэчлэн хийж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, постерыг тогтмол байршуулж цахимаар мэдээллийг хүргэж ажилладаг. Хоногт бүртгэгдэж буй халдвар болон Коронавируст халдвар /Ковид-19/ өөс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх бодлого шийдвэр нэмэлт тунгийн дархлаажуулалтын талаар долоо хоног бүрийн Лхагва гарагт ЭМГ-аас зөвлөгөө мэдээллийг бэлтгэж орон нутгийн “BBS” телевиз, “SB инфо” сайт, “Сүхбаатарын өнгө” сонинд болон Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын пэйж хуудсаар дамжуулан тогтмол мэдээ, мэдээллийг хүргэж байна. BBS телевиз, SB info, Сүхбаатарын өнгө сонинд нийтдээ 2000 орчим мэдээллийг бэлтгэж нийлүүлсэн.	
119	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2021-02-17 Дугаар 2021_41	2. Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Монгол улсын Засгийн газраас тогтоосон сүлжээний дагуу цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 80 иргэнийг мэдэгдэх хуудсаар дуудсанаас 12 дугаар сарын байдлаар 36 иргэн мөнгөн төлбөр төлж 25 219 817 төгрөгийг Төрийн сангын тусгай дансанд төвлөрүүлээд байна.	100

120	Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-17 Дугаар 2021_43	1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус даалгасугай: 1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; 1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх; 1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;	Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг холбогдох хэлтэс агентлаг, сум албан байгууллагуудад хүргүүлж, мөн аймгийн төсвийн нягтлан бодогч нарын болон санхүүгийн албаны фээсбүүк группүүдэд байршуулсан. Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулахдаа тус тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар байгууллагуудад чиглэл өгч ажиллаа. Төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ тогтоон санхүүжүүлэх зарчмаар байгууллага бүрээр батлагдсан төсвийн хүрээнд зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын зарцуулах эрхийг хянаж, нийт өссөн дүнгээр сумдын санхүүгийн дэмжлэгт 7,190,635.6 мянган төгрөг , орон нутгийн төсвийн байгууллагуудад 12,877,840.5 мянган төгрөг, ТЗШилжүүлгийн байгууллагуудад 32,473,639.8 мянган төгрөгний санхүүжилтийн эрхийг олгосон. Тус тогтоолын 1.1, 1.4, 1.9 зэрэг заалтуудын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн төсвийн байгууллагуудын тавилга, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн 3-11 сарын зардлыг 100 хувь, бичиг хэрэг, тээвэр шатахуун , шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн 3-11 сарын зардлыг 50 хувь хойшлуулж төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан дүнгээр зарцуулах эрхийг олгон, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Тус тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн байгууллагуудын 9-11 сарын ус, дулаан, цахилгааны зардлын сарын хуваарийг 20 хувиар бууруулж , төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан дүнгээр зарцуулах эрхийг олгон гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Ингэснээр тухайн хэмнэлтийг “2021 оны батлагдсан дүнд ороогүй, оны дундуур шийдвэр нь гарч халаалтын хугацаа сунгагдсантай холбоотой гарсан нэмэлт зардал”-ыг санхүүжүүлж өр үүсгэхгүй ажиллалаа.	100
-----	---	--	---	-----

		1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; 1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх; 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; 1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх; 1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; 1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.	
--	--	--	--

121	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-24 Дугаар 2021_47	3. Эрсдэлгүй ногоон бүсэд танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг зохих журам, зааврын дагуу ариутгаж халдваргүйжүүлэхэд нэн шаардлагатай ариутгалын бодис, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	БШУЯ-ны санхүүжилтээр бүх цэцэрлэг, сургууль, дотуур байрууд ариутгал халдваргүйтгэл хийх автомакстай болсон. Сургууль, цэцэрлэг, дотуур байрууд хичээлийн жил эхлэхээс өмнө эрүүл ахуй аюулгүй орчин бүрдүүлэх, сурагчид эрсдэлгүй орчинд суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгэж хэвшсэн. Мөн 7 хоногт 1 удаа, сард 2 удаа дотор орчиндоо өөрсдөө ариутгал халдваргүйтгэл хийдэг. БШУС, ЭМС-ын А/292, А/525 тоот хамтарсан тушаалаар батлагдсан түр журмын дагуу эрсдлээс сэргийлэх бэлэн байдлыг хангасан байдалд судалгаа хийхэд нийт сургуулиудын 88.2% гадна орчинд, 94.1% дотор орчинд ариутгал халдваргүйтгэл хийж, 1-3 сарын ариутгалын бодис болон гар халдваргүйтгэлийн нөөц бүрдүүлсэн байна. Мөн 94.1% нь гадна болон дотор нийтийн эзэмшлийн талбайд зай барих тэмдэг тэмдэглэгээтэй, 88.2% нь түр тусгаарлах өрөөг журмын дагуу бэлтгэсэн, 76.5% нь ундны усаа нян судлалын лабораторийн шинжилгээнд шинжлүүлсэн, 94.1% нь хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулж, 88.2% нь хүүхдэд өгөх хоолны цэсийг гаргаж баталгаажуулан, 94.1% нь багш, сурагчид сургалтын үед ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлж, 82.4% нь өөрийн байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж хичээлийн шинэ жилийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан. Цэцэрлэгүүдийн 79.2% нь гадна болон дотор нийтийн эзэмшлийн талбайд зай барих тэмдэг тэмдэглэгээ хийсэн бөгөөд гадаад, дотор орчиндоо ариутгал халдваргүйтгэл хийж, 1-3 сарын ариутгалын бодис болон гар халдваргүйтгэлийн нөөц бүрдүүлсэн байна. Мөн 75.0% нь түр тусгаарлах өрөөг журмын дагуу бэлтгэсэн, 79.2 % нь ундны усаа нян судлалын лабораторийн шинжилгээнд шинжлүүлсэн, 83.3% нь хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулж, 87.5 % нь хүүхдэд өгөх хоолны цэсийг гаргаж баталгаажуулан, 91.7% нь багш, сурагчид сургалтын үед ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлэн, 87.2% нь өөрийн байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.	100
-----	--	--	---	-----

122		4. Энэ тогтоолын 2, 3-т заасан арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны батлагдсан төсвийн багцын хүрээнд зохицуулалт хийж, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Тус тогтоолын хэрэгжүүлэлтэнд анхааран 24 СӨБ-ийн байгууллагуудад шаардлагатай зардлыг тооцон эм бэлдмэлийн зардалд 12,429.9 мянган төгрөг, нормын хувцас, ариутгалын зардалд 35,236.2 мянган төгрөг, Теле болон цахим хичээлийн хүрээнд хичээл үйлдвэрлэлийн зардалд 90,355.4 мянган төгрөгний санхүүжилтийг олгон ажилласан. Танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг зохих журам, зааврын дагуу ариутгаж халдваргүйжүүлэхэд шаардлагатай ариутгалын бодис, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулахад зориулан 18 ерөнхий боловсролын сургуулиуд эм бэлдмэлийн зардалд 25,031.3 мянган төгрөг, нормын хувцас, ариутгалын зардалд 25,234.0 мянган төгрөг, Теле болон цахим хичээлийн хүрээнд хичээл үйлдвэрлэлийн зардалд 114,526.0 мянган төгрөгний санхүүжилтийг олгон ажилласан.	100
123	“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58	3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай.	Залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, ажилтай орлоготой болгох зорилгоор Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх-Оролцоо” төслийн сургалтад орон нутагт 91 залуучууд хамрагдав. Сургалтанд хамрагдсан залуучуудыг аймгийн ажил олгогчидтой уулзалт зохион байгуулж 87 залууг дадлагад гаргаснаар 35 залуу байнгын ажлын байртай болоод байна.	100
124	Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-03-17 Дугаар 2021_67	2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шинэчилсэн дүрмийг Аймгийн ЭХМК бүрэлдэхүүнд танилцуулан, бүрэлдэхүүнийг шинэчлэн 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагааг хэвийн явуулж байна.	100
125		3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан холбогдох дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд,	Холбогдох дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах саналаа ЭХМК-н гишүүд, эмч нараас авч 6 санал нэгтгэн хүргүүлсэн ба эмнэлэг хөдөлмөрийн магадлалын	100

		Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цахимаар хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг хурал хийсэн тухай бүр цахимаар хүргүүлж, вирусийн нөхцөл байдлын үед зайнаас болон цахимаар хуралдаж иргэдийг чирэгдүүлэлгүй хурлыг зохион байгуулж байна.	
126		4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хурал хийх боломжийг бүрдүүлж байртай болгох асуудлыг АНЭ удирдлагад чиглэл өгч ажиллалаа./ковидын нөхцөл байдлын улмаас тусгайлан өрөө гаргаагүй/НДХ-ийн ХБИ-д үйлчлэх ариун цэврийн өрөөний засвар хийх болон угаалтуур, суултуур худалдан авах зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргалаа. Даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг цахимаар болон шинээр орсон иргэдэд биечлэн зөвлөгөө өгч зохион байгуулан ажиллав. Мөн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаанд магадлал хийх ажлыг хэсгийг байгуулан ажиллаж тайлан мэдээг НДЕГ-т хүргүүлсэн.	100
127	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_70	1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: 1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах; 1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах,	430, 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгөд авсан санхүүжилт байхгүй болно. Энэ онд эрх шилжин хэрэгжиж байгаа 17 ТАХ, төсөв өртөг 35,3 тэрбум төгрөг, үүнээс 2021 онд санхүүжих дүн 12,1 тэрбум төгрөг, гүйцэтгэлээр 9,2 тэрбум төгрөгийн буюу ажлын гүйцэтгэл 76,3 %-тай санхүүжсэн.Ковид 19 цар тахлаас шалтгаалан бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн,хөл хорио тогтоосон, хил гааль хаагдсан барилгын материалын хомсдол,үнийн өсөлт,ажиллах хүчний өвчлөл зэргээс хөрөнгө оруулалтын ажлууд удааширсан.ЗГ-ын 2021 оны 379 дүгээр тогтоолын дагуу 4 төсөл арга хэмжээний 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд төвлөрүүлсэн.УТХО-аар шинээр хэрэгжих эрх шилжүүлсэн 13,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулан ажилласан.Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн газар,бусад мэргэжлийн байгууллагаас олгож буй зөвшөөрлийг шуурхай олгох,хөрөнгө оруулалтын ажлыг цаг алдалгүй зохион байгуулан ажилласан.УТХО-ын барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төв,	100

		төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарах; 1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байхаар тооцож ажиллах; 1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажиллах; 1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллах; 1.6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах.	Аймгийн ГХБХБГ,автозамын хувьд "Аварга зам" ХХК, Зам тээврийн хөгжлийн төв гэрээний үндсэн дээр тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.Энэ онд шинээр Уулбаян сумын 240 суудалтай соёлын төвийн барилга, Мал эмнэлгийн ариутгалын функт, 50 ортой дотуур байрны барилга,Мал угаалгын суурин ванн ашиглалтад орсон.Өмч хөрөнгийг ашиглалтад хүлээн авахад өмчийн төлөөлөл тогтмол орж ажиллаж байна.Мөн аймгийн СТСХ,ОНӨГ-тай хамтран 2021 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг тулган хэрэгжсэн төслүүдийн эзэмшигч ашиглагчийг тогтоон данс бүртгэлд тусгуулах талаар албан тоот,аймгийн ИТХТ-ээр шийдвэр гаргуулан ажилласан. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд захиалагч,захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй талууд байнгын хяналт тавьж, хяналтыг хэрэгжүүлж ирсэн тухай бүр тухайн төсөл дээрх тулгамдсан асуудлыг сонсож, тэмдэглэл үйлдэн гарц гаргалгаа шийдэлд тухай бүр хүрч ажилласан.	
128	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай 2021-04-08 Дугаар 2021_93	5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ тогтоон санхүүжүүлэх зарчмаар байгууллага бүрээр батлагдсан төсвийн хүрээнд зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын жилийн зарцуулах эрхийг хянаж, нийт өссөн дүнгээр сумдын санхүүгийн дэмжлэгт 7,190,735. мянган төгрөгний , орон нутгийн төсвийн байгууллагуудад 12,877,840.5 мянган төгрөгний, ТЗШилжүүлгийн байгууллагуудад 32,473,639.8 мянган төгрөгний санхүүжилтийн эрхийг тус тус олгож, төрийн байгууллагуудын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган, өр авлага үүсгэхгүй ажиллалаа.	100
129	Техникийн зохицуулалт батлах тухай 2021-05-19 Дугаар 2021_148	2. Агаарын чанарын техникийн зохицуулалтыг 1 дүгээр хавсралт, усны чанарын техникийн зохицуулалтыг 2 дугаар хавсралт, хөрсний чанарын техникийн зохицуулалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.	Тус тогтоолыг sukhbaatar.gov.mn вэб сайтад байршуулснаас гадна 13 сумын Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газруудад хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2021 оны 11 сарын 10-ны өдрийн 5/1101 тоот	70%

		2. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга)-т тус тус үүрэг болгосугай.	албан бичгээр хүргүүлсэн. Тус тогтоол нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөгдөж эхлэх тул 2021 онд тайлан мэдээ гараагүй болно.	
130	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2021-06-16 Дугаар 2021_168	2. “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 4 дэх заалтын “-Боловсрол, соёл, урлагийн газар” гэснийг “-Боловсролын газар; -Соёлын хэлтэс” гэж өөрчилсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасан Соёлын хэлтсийг байгуулахдаа Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд одоо ажиллаж байгаа “Боловсрол, соёл, урлагийн газар”-аас холбогдох чиг үүрэг, орон тоог цалингийн сан, түүнд ногдох үйл ажиллагааны зардлын хамт шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийж, тус хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2021 оны А/501 захирамжаар Соёлын хэлтсийг байгуулж, бүтэц, орон тоог 10 хүнтэй байхаар баталсан. Б/25 захирамжаар Соёлын хэлтсийн даргыг томилон, Соёлын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтнийг Боловсрол соёл урлагийн газраас шилжүүлэн ажиллуулах, нягтлан бодогчийн хавсран ажиллуулах зохион байгуулалтыг хийж, соёлын хэлтсийн хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангаж, 2021 он дуустал цалин, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн.	100
131		3. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах боломжоор хангах зорилгоор Соёлын хэлтсийн орон тоог 2022 оноос үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тооцож тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын сайд Ч.Номин, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Соёлын хэлтсийг 11 орон тоотой жилийн төсвийг 216,0 сая байхаар улсын төсөвт баталсан. Байгууллагуудын тогтмол зардал, урсгал засвар, мөн ТҮ ангилалд хамаарах албан хаагчдын цалингийн санг орон нутгийн төсөвт тусган баталсан.	100
132	Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай 2021-06-23 Дугаар 2021_171	4. Улсын баяр наадмаас бусад баяр, уул, овооны тахилга, наадам, тэмдэглэлт ой, хурдан морины уралдаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын тохиолдол тасралтгүй нэмэгдэж буйтай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 06 сарын 04-ний А/377 дугаар захирамжаар уул, овооны тахилга, наадам, тэмдэглэлт ой, хурдан морины уралдаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байж, “Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг	100

			баримталж ажиллахыг сумдын засаг дарга нарт үүрэг болгосон. Уул, овооны тахилга, наадам, тэмдэглэлт ой, хурдан морины уралдаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаагүй.	
133	Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-06-23 Дугаар 2021_173	3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	2021 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 21 удаа хуралдаж, 272 хүүхэд орсноос байнгын асаргаа шаардлагатай 221 хүүхэд байна. Үүнээс: харааны бэрхшээлтэй 16, сонсгол хэл ярианы бэрхшээлтэй 14, хөдөлгөөний бэрхшээлтэй 73, оюуны бэрхшээлтэй 54, бусад бэрхшээлтэй 64 хүүхэд байна. Мөн байнгын асаргаанд байх шаардлагагүй эдгэрсэн 2 хүүхдийн байнгын асаргааг цуцалсан байна. ЕБС-д 107 хүүхэд, тусгай сургуульд 7, СӨБ-д 41 хүүхэд хамрагдсан. Боловсролын бусад үйлчилгээнд 27 хүүхэд хамрагдаж байна. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг тусгаад байна.	100
134	Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-07-02 Дугаар 2021_183	2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт нэмэгдэж, улсын хэмжээнд халдварын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын Хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд хязгаарлаж, Ардын хувьсгалын 101 жилийн ой, Үндэсний их баяр наадамтай хамтатган тэмдэглэх нь зүйтэй гэж үзсүгэй. 2. Аймаг, сумдын баяр наадам, хурдан морины уралдаан, уул, овооны тахилга, тэмдэглэлт ой зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт нэмэгдэж, улсын хэмжээнд халдварын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан аймгийн Засаг дарга 2021 оны 06 сарын 29-ний А/402 дугаар захирамж гаргаж, бүх сум, агентлаг албан байгууллагуудад хүргүүлэн Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг мөрдөн, мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн халдвар хамгааллын дэглэмийг сахиж ажиллахыг үүрэг болгож, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газарт үүрэг болгосон.	100
135	Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-07-20 Дугаар 2021_212	2. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Шинэчлэн батлагдсан дүрмийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, аймаг,	Энэ оны хувьд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комиссын 18 дүгнэлтийг Барилгын тухай хууль, Засгийн газрын 317, 212 дугаар тогтоолуудыг үндэслэн гаргаж, комисс зохион байгуулах ажлыг 90 хувиас дээш ирцтэйгээ ажлуулсан байна.	100

		нийслэлийн хэмжээнд хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоол, “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.		
136	Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-07-20 Дугаар 2021_213	2. “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Шинэчлэн батлагдсан дүрмийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, аймаг, нийслэлийн хэмжээнд хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 68 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 171 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.	Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа болон 2021, 2022 онуудад хэрэгжих төсөл арга хэмжээнд Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл уламжлал /Цаасан хэлбэрээр/-10, цахим хэлбэрээр-9, үргэлжлүүлэх зөвшөөрөл-7. Зургийн даалгавар-38 боловсруулж ажилласан байна. Мөн эскиз зураг болон шинээр хийгдсэн 27 ажлын зургийг хянаж баталгаажуулсан байна.	100
137	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2021-07-20 Дугаар 2021_214	2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай.	2021-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр аймгийн төвийн 5-р тойргийн 5,65 км, Баруун-Урт сумын 1-р баг, ахмадын амралт сувилал орчмын 3,03 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажил эхэлсэн. Тус төслүүдэд хэрэглэх Түгээмэл тархацтай ашигт малтмал болох хайрга, дайргыг энэхүү тогтоолоор ашиглах зөвшөөрлийн талбайг баталсан. Аймгийн Засаг даргын 2021 оны А/544 дүгээр захирамжаар тогтоолыг хэрэгжүүлэх, хяналт тавих чиглэлээр гүйцэтгэгч компани “Монгол зам групп”, “Ханан салхит” ХХК –иудад ТТАМ ашиглах, нөхөн сэргээлтийн хариуцан ажиллахыг даалгаж, төлбөрийг орон нутагт төвлөрүүлэх, нөхөн сэргээлтийг хариуцан ажиллах, үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагууд, сумд хяналт тавьж ажиллах үүрэг чиглэлийг өгсөн.	100

138		3. Авто замын барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, тус үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн Засаг даргын 2021 оны А/544 дүгээр захирамжаар гүйцэтгэгч компани, сумын Засаг дарга, мэргэжлийн байгууллага, хэлтэст тодорхой үүрэг чиглэлийг өгсөн. Авто зам, замын байгууламжийн ажлууд 2022 онд дуусна.	100
139	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2021-07-28 Дугаар 2021_220	2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт үүрэг болгосугай.	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 72 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн засаг даргын 2020 оны А/677 дугаар захирамжаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах 10 иргэнийг элсүүлэн авч Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/377 дугаар захирамжаар Зэвсэгт хүчний 338 дугаар ангийг түшиглэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан.	100
140	Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2021-07-28 Дугаар 2021_221	2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг шуурхай зохион байгуулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд тус тус даалгасугай: 2.1. Улсын хэмжээнд 2021-2022 онд өвөлжих болон хэрэгцээлэх малын тоог малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тохируулан аймаг, нийслэл, сум, дүүргээр нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах малын тоог тодорхойлж, экспортлох төлөвлөгөө, хуваарь гарган, энэ чиглэлээр хүнсний болон хөнгөн үйлдвэрүүдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2021-2022 онд аймгийн хэмжээгээр 13 сумын 67 багийн 4882 хот айлын 8154 малчин өрхийн 4022,8 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан дүн гараад байна. 2021 онд 1012.5 мянган толгой буюу нийт мал сүргийн 25 орчим хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах тооцоолол гарсан. Аймгийн төвийн хүн амын хаврын хэрэгцээнд "Дарьт шүтээн" ХХК-ны "Баян тал" махны үйлдвэр 10 тн, "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК, "Түмэнцагаан ноос" хоршоо, "Өөдлөх боломж" ХХК-тай тус бүр 5.0 тн мах нөөцлөх гэрээ байгуулсан.	100
141		2.7. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хадлан тэжээл бэлтгэл, ургац хураалтын ажилд оролцож байгаа аж ахуйн нэгж, иргэдэд халдвар хамгааллын урьдчилан сэргийлэх горим, дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Үр тарианы аж ахуйн нэгжүүд, төмс, хүнсний ногоо тариалагчдад халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллах талаар тогтмол мэдээлэл хүргэж ариутгалын бодис, нэг удаагийн халдвараас хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажилласан. Байгалийн хадлан бэлтгэх Тариалалт, ургац хураалтын үед 6 аж ахуй нэгжийн 55	100

			ажилтан халдвар хамгааллын урьдчилан сэргийлэх горим, дэглэмийг чанд мөрдүүлж ажиллалаа.	
142		3. Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед авах хариу арга хэмжээний талаар дор дурдсан ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө баталж, биелэлтэд хяналт тавих; 3.2. Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийг тогтоож, хил заагийг тодорхойлон ашиглалт, хамгаалалтыг сайжруулан 2021-2022 оны өвөл, хаврын улиралд өөрийн аймаг, сумдын малыг оторлуулах; 3.3. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, төрийн холбогдох байгууллагын зөвшөөрлийн дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах; 3.4. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэх талбайг гэрээгээр ашиглуулах, малчин, мал бүхий иргэнээр байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх; 3.5. Бог малын тохироогоор дутагдаж байгаа хээлтүүлэгчийг нөхөн бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, малын чанар сайжруулахад анхаарах; 3.6. Малчдыг малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, гурил, тэжээлийн үйлдвэрүүдтэй харилцан бараа, бүтээгдэхүүн солилцох (бартер), малаа зарж борлуулахад нь арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах; 3.7. Үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арьс шир, ноолуурын түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх ажлын төлөвлөгөө, хуваарь гарган хэрэгжилтийг хангах;	Аймгийн хэмжээнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангалт 84.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 10 хувиар илүү байна.Ажлын хэсэг сум дундын болон сумын отрын нөөц нутаг тогтоох ажлыг газар дээр нь очиж тодруулан ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн болон ашигт малтмалын ашиглалт,хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхардуулахгүйгээр зураглаж тухайн сумын ИТХ-н шийдвэр гарч Сүхбаатар,Наран,Дарьганга,Мөнххаан,Түмэнцогт сумдад 30 байршилд 397779.2га газрыг сумын отрын нөөц нутгаар тогтоон зураглал мэдээллийн сан үүсгэсэн нь нийт бэлчээрийн 5.7 хувь байна.Хилийн цэргийн..ангийн зөвшөөрлөөр Эрдэнэцагаан сумын 118 өрхийн 87.1мян мал,Баяндэлгэр сумын 51 өрхийн 51.4мян мал,Дарьганга сумын 49 өрхийн 33.0мян мал,Наран сумын136 өрхийн 60.6мян мал,Онгон сумын 40 өрхийн 50.0мян мал,Дарьганга сумын Тусгай хамгаалалтай нутгийн захиргааны зөвшөөрлөөр Дарьганга сумын 268 өрхийн 104.2мян мал,Наран сумын 44 өрхийн 44 өрхийн 24.8мян мал нийт 394 өрхийн 282.1мян мал хилийн зурваст,312 өрхийн 129.0мян мал тусгай хамгаалалттай бүс нутагт өвөлжиж,хаваржина.Байгалийн хадлан бэлтгэх техникийн засвар үйлчилгээг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулснаар 7 суманд хадлангийн 60 хэсэг салаа,173 машин техник,тоног төхөөрөмж,210 хүн байгалийн хадлан бэлтгэх ажилд оролцсон.Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 17200тн өвс бэлтгэсэн.Судан өвс,овьёос,арвай зэрэг малын тэжээлийн ургамлыг Түмэнцогт сум 2000га,Эрдэнэцагаан сум 400га,Баруун-Урт сум13 га,Сүхбаатар суманд 500га-д нийт 2913га талбайд тариалалт хийж,4913тн ургац хураан авсан.	100

		3.8. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах; 3.9. Бэлчээр дэх худаг, гар худаг болон инженерийн хийцтэй худгийг өөрийн хөрөнгөөр шинээр гаргасан иргэд, малчдын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, арга туршлагыг нийтийн хүртээл болгох; 3.10. Мал бордох аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хэрэгцээнд стандартын шаардлага хангасан шинэ мах нийлүүлж байх арга хэмжээг авах; 3.11. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээний бэлэн байдал, шуурхай удирдлагаар хангаж ажиллах.		
143	Үдийн хоолны норматив тогтоох тухай 2021-08-11 Дугаар 2021_237	4. Энэ тогтоолын 1, 3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд 2021 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг 2021 онд батлагдсан төсвийн багцдаа зохицуулалт хийж, 2022 оноос улсын болон орон нутгийн төсвийн төсөлд зохих журмын дагуу тусган хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	2021 оны тодотгосон төсвөөр нийт 16 ЕБС-ийн үдийн цайны санхүүжилт 597,045.0 мянган төгрөг байсан бөгөөд 237 дугаар тогтоолын дагуу Үдийн цайны норматив 1500 төгрөг болон өөрчлөгдсөнөөр сургуулиудын үдийн цайны санхүүжилт дутан өр үүссэн. Ийм учраас БШУ-ны сайдын 2021.11.11-ний өдрийн 1а/5843 албан тоот болон аймгийн Засаг даргын А/720 захирамжийн дагуу 2021 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийн 27,385.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 624,430.0 мянган төгрөгний санхүүжилт аван хичээл сургалтын үйл ажиллагаа явуулсан байна. Нийт 16 ЕБС-ийн 1-5 дугаар ангийн нийт 25,169 хүүхэд Үдийн цай хөтөлбөрт хамрагдсан байна.	100
144	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай 2021-10-13 Дугаар 2021_314	2. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор энэ тогтоолын хавсралтад заасан Засгийн газрын тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. 2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан салбар, орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын	Нийгмийн салбарт хэрэгжиж байсан Төрөөс баримтлах бодлого-6, Үндэсний стратеги-3, Үндэсний хөтөлбөр -21 хүчингүй болсонтой холбогдуулан орон нутагт хэрэгжиж буй аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 29 ний өдрийн 38 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 дэд хөтөлбөрийг хүчингүй болгох саналыг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн ИТХ-аар хүчингүй болгосон.	100

		гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.		
145	Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай 2021-10-13 Дугаар 2021_315	3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.	2021 оны 11 сарын 01-ний өдрөөс 12 сарын 01-ний өдрийг хүртэл улс даяар явагдаж байгаа бөгөөд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны 10 сарын 26-ний өдрийн А/611 тоот захирамж гарч тооллогын комисс, комиссын гишүүдийг баталсан. Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт 1347 ААНБ, 1156 хувиараа хөдөлмөр эрхлэгч тоологдсон. Тус үйл ажиллагаанд 16,0 сая төгрөг зарцуулж, 100 хувь хамрагдсан	100
146	Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар 2021_359	2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг техникийн хяналтын зардлын тооцооны хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Уг тогтоолын дагуу эрх шилжиж ирээгүй ажлуудын техникийн тодорхойлолт, зураг төсөв, ажлын даалгаврыг холбогдох яамдад тогтоосон хугацааны дотор хүргүүлсэн.. Эрх шилжиж ирсэн ажлуудын зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг ОНӨГ-т хүргүүлээд байна.	100
147		4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай.	2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 90 нэр төрлийн төсөл арга хэмжээ тусгагдснаас 22 төсөл арга хэмжээ нь харьяа байгууллагад эрх шилжсэн, 9 төсөл арга хэмжээ нь шууд худалдан авалтаар хэрэгжүүлсэн байна. Нийт 59 нэр төрлийн худалдан авах төсөл арга хэмжээг цахим системээр зохион байгуулахаас (tender.gov.mn) давхардсан тоогоор 105 удаа тендерийг зохион байгуулж ажилласан байна. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээ зэрэг холбогдох баримт материалыг тухай бүр цахим системд байршуулсан байна.	100
148	Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох	5. “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын чиг үүргийн шинжилгээг хийж, аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын	Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын дагуу Засаг даргын Тамгын газарт чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын	70%

	тухай 2021-12-14 Дугаар 2021_377	хүрээнд ажиллах агентлагийн хооронд чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	30 -ны өдрийн А/ 738 дугаар захирамжаар байгуулан Тамгын газрын хэлтэс, бодлогын мэргэжилтнүүд, агентлаг албадын хооронд чиг чиг үүргийн давхардал хийдэл байгаа эсэхэд шинжилгээ хийж байна.	
149	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-12-14 Дугаар 2021_397	1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 1.1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн өмнөх онд хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж санхүүжүүлэх; 1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах; 1.3. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	1.2 2021 оны төсвийн жилд санхүүжих 4 төсөл арга хэмжээ ковидын нөхцөл байдлаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй. ЗГ-ын 397 дугаар тогтоолын дагуу Мал угаалгын суурин ванн -66.3 сая төгрөг, Инженерийн хийцтэй худаг гаргах -374.6 сая.төгрөг, Соёлын төвийн барилга/ Баяндэлгэр 300 суудал/-513.2 сая төгрөг, Дарьганга зуслан орчин үеийн стандартад нийцсэн аялал жуулчлалын цогцолбор болгох -1080.4 сая төгрөг нийтдээ 2034.5 сая.төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд гүйцэтгэгч компанийн хүсэлтийг үндэслэн байршуулсан. Гүйцэтгэгч компаниудтай гэрээний хугацааг сунгах, 2022 онд ажиллах ажлын график төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан.	100
150	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2021-12-22 Дугаар 2021_392	3. Коронавируст халдвар /КОВИД-19/-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	МУ-ын Засгийн газрын 2020 оны 213 дугаар тогтоолын хүрээнд Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулдаг Цайрт Минирал ХХК-ны гүүрний барилга угсралтын ажил хийхээр БНХАУ-ын 52 иргэнийг 7 хоног тусгаарлан ажилах байранд байршуулан, үзлэг шинжилгээнд хамруулан, зөвшөөрлийг олгон ажиллалаа. 2022 онд ажиллуулах 46 гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дэмжих санал олгож, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Сүхбаатар аймагт гадаадаас уул уурхай, боловсрол, шашны чиглэлээр 106 иргэн оршин сууж байна. Тэдгээр иргэдийг эрүүл мэндийн анхан	100

		4. Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг хөдөлмөр эрхлүүлэх, буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Улсын онцгой комисс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тухай бүр мэдээлж байхыг холбогдох сайд нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комисс (С.Амарсайхан)-т тус тус даалгасугай.	шатны болон лавлагаа шатлалын эмнэлгүүдэд урьдчлан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан ажиллаж байна	
Ерөнхий сайдын захирамж				
151	Төлөвлөгөө батлах тухай 2020-07-01 Дугаар 2020_99	2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хүн амын дундаж наслалт 73,29, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.04, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 78.5, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 10.1 насаар бага байна. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга байгуулсан хамтран ажиллах гэрээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг тусгайлан тусгалаа. Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газраас эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хорт зуршлыг бууруулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ, подкаст нэвтрүүлгийг бэлтгэн иргэдэд тогтмол хүргэж байна.	100
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
152	2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 2 дугаар тэмдэглэл 2019-01-09 Дугаар 2019_2	XXIII.3. . -Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.1.2-т заасны дагуу олон нийтийн цагдаагийн ажилтан харьяа нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, иргэдэд сурталчлахад дэмжлэг үзүүлж, гэмт хэрэг, ослын гаралтыг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Аймгийн хэмжээнд Баруун-Урт суманд 10, бусад сумдад 14 нийт 24 олон нийтийн цагдаа ажиллаж байгаа бөгөөд хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг зөрчлийг бууруулах чиглэлээр эргүүл, хяналт шалгалтад ажиллаж 362 зөрчил илрүүлж эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэсэн байна..	100
153	2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2019-12-11	XXIX.3.. Өмч хувьчлалын 1991-1996 оны нэгдсэн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Архивын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт;	Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 1/347 тоот бичгээр 1991-1996 оны өмч хувьчлалын нэгдсэн мэдээлэл судалгааг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. хэрэгжсэн заалт тул хасах саналтай байна / судалгааг гарган хүргүүлсэн 2020 онд/	100
154	Дугаар 2019_54	XXIX.4.. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийн өнөөгийн байдал, орон нутгийн өмч хувьчлалын	Орон нутгийн өмчөөс 1999-2020 онд хувьчлагдсан/ худалдсан/ аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн судалгааг нэгтгэн хүргүүлсэн.	100

		талаарх судалгааг гарган, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт.	Нийт 75 нэр төрлийн 1,405,682,7 төгрөгийн эд хөрөнгийг аж ахуйн нэгж иргэнд хувьчилсан /худалдсан/ байна. хэрэгжсэн заалт тул хасах саналтай байна / судалгааг гарган хүргүүлсэн 2020 онд/	
155	2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22	ХҮИИ.2. . 2. Дараахь арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах; 2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах.	2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 90 нэр төрлийн төсөл арга хэмжээ тусгагдсан. Мөн улсын төсвөөс 9 нэр төрлийн төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн байна. Үүнээс харьяа байгууллагууд руу 22 нэр төрлийн бараа ажил үйлчилгээ эрх шилжүүлсэн байна. Мөн Засгийн газрын тогтоолын дагуу 2 нэр төрлийн барааны тендер, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын 2021 оны 03 сарын 05-ны өдрийн 1/581 тоот албан бичгийн дагуу 13 барааны тендер тус тус хүчингүй болсон. Нийт 90 нэр төрлийн бараа ажил үйлчилгээ байна. 86 төсөл арга хэмжээ зарлагдаж, гүйцэтгэл 95,5%-тай байна. Тайлант хугацаанд нийт зарлагдсан 86 нэр төрлийн бараа ажил үйлчилгээний 8 нь ШХА байсан. Үлдсэн 78 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг цахимаар зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.	100
156	2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 23 дугаар тэмдэглэл 2020-04-08 Дугаар 2020_23	XIII.1.2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг нийцүүлэн боловсруулах, шинэчлэн батлуулах ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сангаас хамтран хэрэгжүүлж буй "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал" төслийн хүрээнд орон нутгийн оролцоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг зарлаж "Газар дэлхий" ХХК шалгарч гэрээ байгуулж ажиллаж байна.	100

157	2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл 2020-05-13 Дугаар 2020_31	ХҮ.4. . Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зарим суманд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоо байгуулж, кластерын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Баруун-Урт суманд сард 200 тонн ноос угаах үйлдвэр 2022 онд ашиглалтанд орох гэж байгаатай холбогдуулан тус үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор сум бүрд хоршоодоор дамжуулан ноос хүлээн авах цэг байгуулах газрын асуудлыг 2022 оны аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд оруулан батлаад байна. 2022 онд “Хоршоог хөгжүүлэх сан” үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан сангийн журмын төсөлд хоршоодыг кластерын тогтолцоогоор хөгжүүлэх санал хүргүүлэн ажилласан. Сангийн журам батлагдах үеэр малчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хоршиж үйл ажиллагаа эрхлэхийн ач холбогдол болон энэ талаарх төрийн бодлогыг сурталчлах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	70%
158	2020 оны 9 дүгээр сарын 16-ний өдөр 50 дүгээр тэмдэглэл 2020-09-16 Дугаар 2020_50	XI.4. 2. Хилийн Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомтоор гадаадын инженер техникийн ажилтныг нэвтрүүлэх болон ачаа тээврийн үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан тухайн боомтуудад ариутгал, халдвар хамгааллын дэглэм сахиулах, мөрдүүлэх, эрүүл ахуйн болон бусад хяналт, шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд гүйцэтгэж, аюулгүй байдлыг хангуулан ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга) , Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт.	Бичигт-Зүүнхатавч боомтоор гадаадын инженер техникийн ажилтан хил нэвтрүүлээгүй. Тайлант хугацаанд улсын хилээр нэвтэрсэн нүүрс, татан авалтын тээврийн хэрэгсэл, газрын тосны нийт улсын хилээр нэвтэрсэн 9630 тээврийн хэрэгсэлд гадаргууг мананцаржуулах болон хуурай аргаар халдваргүйжүүлэлт хийж улсын хилээр нэвтрүүлсэн. МХЕГ-ын даргын 2020 оны А/31 дүгээр тушаалын дагуу 9661 тээврийн хэрэгслийн жолоочдоос “Жолоочийн эрүүл мэндийн хуудас”-аар асуумж авч, зөөврийн термокамер, термометрээр биеийн халууныг хэмжин эрүүл мэндийн тандалт судалгааг өдөр бүр тогтмол хийж хэвшин мэдээллийн сан үүсгэсэн халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.	100
159	2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69	Ү.. Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав.	Цахим шилжилтийн ажлын хүрээнд сумд болон аймгийн вэб сайтыг үндэсний дата төвийн серверт холбож бүх төрийн албан хаагчдад gov.mn вэб мэйл, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем “ERP”-д холбосон. Мөн төрийн үйлчилгээг цахимжуулж 12 төрийн байгууллагын 76 үйлчилгээг цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д нэгтгэснээр төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлсэн.	100

160	2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	XII.2.4. Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Улсын Их Хурал, Засгийн газраас батлахаар хуульчилсан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Нийт сумдын эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдэд эрх зүйн сургалт , сурталчилгааны агуулга , түгээх, ажлын нэгдсэн арга зүй, шалгуур үзүүлэлт үр дүнг тооцох талаар Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөр, аргачлалын талаар сургалт зохион байгуулсан ба тус сургалтын үеэр шинээр батлагдах хууль, тогтоомжийн төслүүдийн талаар мэдээлэл өгч, сүхбаатар аймгийн ЭБАТ-уудын нэгдсэн групп, агентлаг, албад, төсөвт байгууллагууд зэрэг групп хуудсуудаар тогтмол мэдээлэл солилцон чиглэл хүргүүлэн ажиллаж байна.Эрх зүйн чиглэлээр бусад байгууллага, төрийн бус байгууллагаас сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад тэдгээрийг байраар тухай бүр хангах, орон нутгийн BBS телевизэд зар мэдээллийг үнэ төлбөргүй явуулж өгөх, нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-аас сургалтын цайны завсарлагыг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн ажилтан сургалт, мэдээллийн үед зураг авч мэдээлэл бэлтгэх аймгийн албан ёсны сайт sukhbaatar сайт дээр байршуулах зэрэг дэмжлэгийг тогтмол үзүүлэн ажиллаж байна. Тайлант онд МУ-ын ЗГХЭГ-ын 2021 оны санал авах тухай/Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай бусад хууль, тогтоомжийг нийцүүлэх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, нэр томьёог жигдлэх зорилгоор боловсруулсан Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/ ХЭГ/2394 тоот албан бичгийг сумд, агентлагуудад танилцуулсан	100
161	2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2021-03-17 Дугаар 2021_18	ХҮ.7.2. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын явцын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Төслийг боловсруулах, батлуулах ажлын хүрээнд хийгдэх иргэд, олон нийтийн оролцоог хангуулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж, холбогдох	Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад холбогдох яам, газруудтай хамтрач ажиллах, мэдээ мэдээллээр хангах зэрэг үүрэг бүхий аймгийн засаг даргын 2019 оны А/200 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийг 2021 оны А/590 дугаар захирамжаар шинэчлэн зохион байгуулж ажиллуулж байна. Ажлын хэсгийг онлайнаар хуралдаж шаардлагатай тоо баримт, мэдээ мэдээллийг солилцож, цаашид хамтарч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг	100

		байгууллагатай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	гаргалаа. Төслийг боловсруулах, батлуулах ажил хугацаа болоогүй судалгааны түвшинд байгаа бөгөөд улсын хэмжээнд иргэд, олон нийтийн оролцоог хангуулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.	
162	2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19	II.. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав.	2021 онд эрх шилжин хэрэгжиж байгаа 17 ТАХ, төсөв өртөг 35,3 тэрбум төгрөг, үүнээс 2021 онд санхүүжих дүн 12,1 тэрбум төгрөг, гүйцэтгэлээр 9,2 тэрбум төгрөгийн буюу ажлын гүйцэтгэл 76,3 %-тай санхүүжсэн. 2021 онд УТХО-аар шинээр хэрэгжих эрх шилжүүлсэн 13,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулан ажилласан. Ковид 19 цар тахлаас шалтгаалан бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн, хөл хорио тогтоосон, хил гааль хаагдсан барилгын материалын хомсдол, үнийн өсөлт, ажиллах хүчний өвчлөл зэргээс хөрөнгө оруулалтын ажлууд удааширсан. ЗГ-ын 2021 оны 379 дүгээр тогтоолын дагуу 4 төсөл арга хэмжээний 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд төвлөрүүлсэн.	100
163		II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Боловсролын яамны захиалгаар Эрдэнэцагаан суманд баригдаж буй 200 ортой цэцэрлэг, Баяндэлгэр суманд баригдаж буй 200 ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгч нарт хариуцлага тооцох, гэрээг цуцлах саналыг аймаг орон нутгийн зүгээс харьяа яаманд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж ажилласан.	100
164	2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07 Дугаар 2021_22	IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	2022 оны улсын төсвийн төсөлд нийт 47 төсөл арга хэмжээний саналыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн системд /pmis.publicinvestment.gov.mn/ улсын шивж оруулсан. Уг тушаалын дагуу төсөл бүрийн хураангуй болон дэлгэрэнгүй мэдээлэл, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ, зураг төсөв, холбогдох баримт бичгийг цахим системд оруулан 2021 оны 05 сарын 01 дотор шивж системээр болон албан бичгээр илгээсэн. 7/1-7/15 нд их засвар тоног төхөөрөмжийн санал шивэгдэх одоогоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100

165	2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл 2021-04-14 Дугаар 2021_24	ҮИИ.4. . Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчлэх, тодотгох ажлыг 2022 онд бүрэн дуусгаж, батлуулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Архангай, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгийн Засаг даргад тус тус даалгав.	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сангаас хамтран хэрэгжүүлж буй "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал" төслийн хүрээнд орон нутгийн оролцоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг зарлаж "Газар дэлхий" ХХК шалгарч гэрээ байгуулж ажиллаж байна.	100
166		ҮИИ.4. . Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрыг бусдад шилжүүлэхгүй байх, бүрмөсөн хориглох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрыг бусдад шилжүүлээгүй	100
167	2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр 31 дүгээр тэмдэглэл 2021-05-19 Дугаар 2021_31	ХҮИ.8.2. Эрх шилжүүлсэн болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдах спорт цогцолборын барилга барих, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, зураг төсөв, ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг нэн даруй боловсруулж, сонгон шалгаруулалтыг яаралтай зарлах арга хэмжээ авахыг аймаг, дүүргийн Засаг дарга нар, Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц), Төрийн худалдан авах ажиллагааны газар (Х.Улам-Өрнөх)-т;	Биеийн тамир спортын улсын хорооноос эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй	100
168	2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36	XII.11.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих замаар тухайн орон нутгаас нийлүүлэх болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжийг судалж, шийдвэрлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд;	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлийг нийлүүлэх ажлыг Дөрвөн гэгээн эрдэнэ, Дарьтшүтээн ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	100
169		XII.11.4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй сургуульд шинээр зориулалтын байр барих ажлын зураг төслийг 2021 онд багтаан боловсруулж, 2022 оноос улсын төсөвт тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий	Нийт сургуулиудын 5 буюу 31,2% нь гал тогооны тоног төхөөрөмж хангалттай, 11 буюу 68,8% нь хангалтгүй. Цэцэрлэгийн 16 буюу 66.7 % нь гал тогооны тоног төхөөрөмж хангалттай, 8 буюу 33.3% нь хангалтгүй , тоног төхөөрөмж дутагдалтай байна. Бага боловсролд 7236 суралцагч суралцаж "Үдийн хоол"	100

		талбайг бусдад ашиглуулсны төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах боломжийг судлан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	хөтөлбөрт 100 хамрагдаж байна. Сургууль, цэцэрлэгүүдэд эх орныхоо хөрсөнд ургасан хүнс хүнсний ногоо түлхүү хэрэглэх, дотоодын хүнсний бүтээгдэхүүнийг авч ашиглахыг зөвлөдөг. Сургууль цэцэрлэгийн 80.0% нь өөрийн хүлэмжинд тарьсан хүнсний ногоог хүнсэндээ хэрэглэж байна. Мөн Үдийн цайг хоол болгосонтой холбоотойгоор бүх сургуулиуд өөрийн гал тогоогоор дамжуулсан үдийн хоолыг хүргэж байна.Сургууль бүр бэлэн бүтээгдэхүүн хэрэглэхгүй болж өөрийн аймгийн, сумын хүнсний дэлгүүрүүдээр дамжуулан худалдан авалтыг хийдэг. Цар тахлаас үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор худалдан авах тендер хийгдээгүй өмнөх оны гэрээг тухайн ААН-тэй сунган ажилласан.	
170		XII.12. . Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Мал эмнэлгийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд даалгав; 2. Байгаль, цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас хорогдсон малын сэг, зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх нарийвчилсан төлөвлөгөө гарган мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжилтийг хангуулан 14 хоног тутам тайлан гаргаж Улсын онцгой комисст ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	1.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх тухай аймгийн Засаг даргын А/416 тоот захирамжийн дагуу 05 дугаар сарын 08-ны өдрөөс 09 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд 51 ажлын хэсэгт 210 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дарьганга, Уулбаян, Эрдэнэцагаан, Халзан, Баяндэлгэр, Онгон, Наран, Түвшинширээ 8-н сумын үхэр-191312, хонь-1059238, ямаа-694137, нийт-1944687 малыг хамруулж 1070,4 м.тун вакцин зарцуулж, гүйцэтгэл 100-тай хийгдэж дууссан. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 13358 том үхэр, 5310 тугал нийт 18668 мал хамрагдаад байна.	100
171	2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2021-07-07 Дугаар 2021_41	ХХҮИ.1. . Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Амрах, аялах зорилгоор орон нутаг, хот хооронд	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Улсын Онцгой комиссын 41 дүгээр тушаалын дагуу амрах, аялах зориулалт бүхий бааз, амралтын газарт ариутгал, халдваргүйжүүлэлтийн	100

		зорчих иргэдийн хөдөлгөөн эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэдэд тавих шаардлага, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулалтын талаар Улсын онцгой комисс хэлэлцэн шийдвэрлэж, тодорхой чиглэл, нэгдсэн байр суурь бүхий үүрэг даалгаврыг аймаг, нийслэлийн Онцгой комисс, Засаг дарга нарт өгч байхаар зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд, харьяалах нутаг дэвсгэртээ болон амрах, аялах зориулалт бүхий бааз, амралтын газарт ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэм, нөхцөл шаардлага, халдвар хамгааллын горимыг чанд мөрдүүлэх, Улсын онцгой комиссын шийдвэр, өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг нэг мөр дагаж мөрдөхийг бүх шатны Засаг дарга нарт даалгав.	дэглэм, нөхцөл шаардлага, халдвар хамгааллын горимыг чанд мөрдүүлэх талаар зөвлөгөө өгч ажилласан.	
172	2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2021-08-04 Дугаар 2021_45	XII.2. . Бүх шатны сургалтын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийг эхлүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс үе шаттайгаар эхлүүлэх бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	2021-2022 оны хичээлийн жилд ЕБС, цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг эхлүүлэн , цэцэрлэгт 4-5 настай хүүхдийг бүрэн хамруулсан.	100
173	2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 49 дүгээр тэмдэглэл 2021-08-31 Дугаар 2021_49	XIII.5.2. Төрийн болон орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгааг хамтран баталж мөрдүүлэх, харуул хамгаалалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгаа"-г боловсруулж, батлуулан харуул хамгаалалтын ажилтныг хариуцгаажуулсан. Уг арга хэмжээний хүрээнд аймгийн Цагдаагийн газартай хамтран соёлын өвийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар цахим сургалт 2 удаа зохион байгуулж, харуул хамгаалалтын ажилчид болон сумдын бүртгэл мэдээллийн санч нарыг хамруулсан.	100

174		XIII.5.4. Харьяалах нутаг дэвсгэр дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Үл хөдлөх хөшөө дурсгалуудыг хашаажуулах хашааны загвар гаргаж, нэг загвараар хашаажуулахаар сумдад хүргүүлсэн ба, шинээр Наран сумын Мандалын болон Хүн ухаа, Ноёны хөндийн хүн чулууд, Онгон сумын Шивээтийн хүн чулууг хашаажуулсан ба нийт 650,0 мянган төгрөг зарцуулсан. Аймгийн хэмжээнд нийт 635 үл хөдлөх дурсгалыг 135 гэрээт хамгаалагчаар хамгаалуулсан. Мөн Тика олон улсын байгууллагад Дарьгангын 13-14 дүгээр зууны үеийн хүн чулуун хөргүүдийн хуулбар хийх төсөл хүргүүлж, нийт 189,5 сая төгрөгийн төсөл дэмжигдсэн. Аймгийн Цагдаагийн газартай хамтран Соёлын өвийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийн талаар цахим сургалт 2 удаа зохион байгуулж сумдын Бүртгэл мэдээллийн санч нарыг хамруулсан. Мөн Цагдаагийн газартай хамтран “Соёлын өв бидний өв” сэдэвт уриалгыг дэвшүүлэн бүх шатны иргэний төлөөллийг оролцуулсан шторкийг бэлтгэн 591 хүнд мэдээлэл хүрсэн байна. Соёлын өвийн эрх зүйн орчин сэдвээр цуврал 2 хичээл бэлтгэж Угсаатны зүйн музей болон соёлын төвүүдийн пэйж хуудсанд байршуулж 2000 гаруй хүн үзсэн байна	100
175	2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51	X.1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Иргэдийг коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3 дугаар тунд хамруулах ажлыг эрчимжүүлэх, эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээ, хурим найр, хурал, зөвлөгөөн зохион байгуулахыг хязгаарлах талаар холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт нарт тус тус үүрэг болгов;	Иргэдийг коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3 дугаар тунд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг байгуулан салбар дундын оролцоог ханган ажилласнаар 2021 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн байдлаар 3 дугаар тунгийн хамрагдалт 56.4 хувьтай улсын хэмжээнд иргэдийн хамрагдалтаар тэргүүлж байгаа бөгөөд вакцины хүндрэл илрээгүй байна. Мөн хамрагдалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд вакцинжуулалтын нэмэлт цэгийг байгуулан аймгийн засаг даргын нөөц сангаас байрны түрээсийн зардлыг гарган амралтын өдрүүдэд нэмэлт цэгийн байнгийн ажиллагааг ханган ажиллаа.Ковид халдварын хүрээг хумих, илэрсэн тохиолдлыг эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор эмнэлгийн орны тоог боломжит хувилбараар нэмэгдүүлэн АНЭ-т 200 орыг нэмэлтээр дэлгэн ажиллуулж зорилтот хүн амыг хэвтүүлэн эмчилж хүндрэл багатайгаар даван туулж байна.	100

176		Х.3. . Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний явц байдлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэгч нарт олгох явцыг үндэслэлгүйгээр удаашруулж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид учруулж буй хүнд суртлыг таслан зогсоохыг захиалагч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, бүх шатны төсвийн захирагч нарт; 2. Гүйцэтгэлийг хянан баталгаажуулдаг захиалагч, захиалагчийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэл, яамдын төрийн сангийн гүйлгээний үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, гарсан зөрчил дутагдлыг арилгах, буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг Авлигатай тэмцэх газарт мэдээлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилт олгохтой холбоотой хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг “Иргэд, олон нийттэй харилцах-1111” төв, “e-mongolia” системээр хүлээн авч, дүн шинжилгээ хийж, танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж нарт; 4. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан хатуу баримтлан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйлгээг шилжүүлэхийг	Эрх шилжин хэрэгжиж буй ажлуудын санхүүжилтийг тухай бүр журмын дагуу, гүйцэтгэгч компаниудад олгож ажилласан .Гүйцэтгэгч компаниудаас гомдол хүсэлтүүд ирээгүй. Барилга угсралтын ажлын хувьд захиалагч болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй талуудын гүйцэтгэл баталгаажуулах процесс удаашралтай. Барилгын хөгжлийн төв аймагт эрх шилжин хэрэгжиж буй ажлуудад аймгийн ЗД-тай гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж байгаа гарын үсэг зурагдах процесс удаашралтай 5 гарын үсэг зурагддаг. Орон нутагт боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт дийлэнхийг эзэлдэг тул төсвийн ерөнхийлөн захирагчдаас заавал барилгын хөгжлийн төвөөр хяналтыг хэрэгжүүлж ажиллах чиглэл хүргүүлдэг/ Засгийн газар, БШУЯ, ЭМЯ-аас/ Барилгын Хөгжлийн төвийн хяналт хэрэгжүүлэх барилга объектулсын хэмжээнд их, хүн хүч дутмагаас орон нутагт хөрөнгө оруулалтын ажлуудад зарим талаар доголдол үүсдэг. Иймд захиалагчийн хяналтыг орон нутагт мэргэжлийн хувийн хэвшлийн баг томилж, үе шат бүр дээр хэрэгжүүлэх нь үр дүнтэй	100
-----	--	--	--	-----

		бүх шатны төсвийн захирагч нарт; 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс санхүүжилтийн гүйцэтгэлийг захиалагч байгууллага хянан баталгаажуулсны үндсэн дээр Сангийн яамнаас гүйцэтгэгч нарт шууд шилжүүлэх цахим системийг нэвтрүүлж, санхүүжилтийн явцыг ил тод нээлттэй болгохыг Сангийн сайд Б.Жавхланд; 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажилт, санхүүжилтийн хугацаа болон зөрчил, хариуцлагын асуудлыг холбогдох хуульд тусгах талаар судлахыг Сангийн сайд Б.Жавхланд.		
177	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55	ХҮ.9.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав;	Аймгийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 сарын 20-ны өдрийн А/721 дүгээр захирамжаар батлуулсан.ЗГ-аас өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу ХАА-ны бэлтгэл ажлыг хангуулах талаар захиалагч талуудтай уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна.	100
178		ХҮ.13.6. “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа бүх байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, урилга, үр дүнг www.tender.gov.mn цахим системд нийтэлж, худалдан авалтыг 100 хувь цахимаар зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан. Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар нийтдээ давхардсан тоогоор 277 бараа, ажил, үйлчилгээний тендерийн урилгыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн бөгөөд үүнээс 261 бараа ажил үйлчилгээний тендерийн үр дүнг цахим системд оруулж олон нийтэд ил тод мэдээлсэн.	100

179	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58	XII.6. . Газар хөдлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд, дарга нарт даалгав: 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 17/12 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны н/206 дугаар тогтоолын хавсралтад заасан газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Газар хөдлөлтийн үед нурах эрсдэл бүхий 63 барилга байгууламжийн судалгааг Газрын харилцаа хот байгуулалтын газар, мэргэжлийн хяналтын газартай хамтран гаргаад байна. Тус ажлын хүрээнд Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэгийг 2021 оны эхэнд шинэ барилгад шилжиж орсон, мөн Баруун-Урт сумын А бүсэд байрлах хуучин байрыг дахин төлөвлөлтөнд оруулж орчин үеийн шийдэлтэй орон сууны хотхон болгохоор төлөвлөлт хийж зураг төслийн ажил хийгдээд байна.	100
180		XII.6.: Аймаг, нийслэлийн хэмжээнд иргэдийг нүүлгэн шилжүүлэх түр байрыг томилгоожуулж, шаардлагатай материал хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Гамшгийн аюулын үед аймгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх түр /хоргодох/ байрыг аймгийн төвийн төр, хувийн хэвшлийн 15 байрыг томилгоожуулж, шаардлагатай материал хэрэгслээр хангах, нөөцийн тооцоо судалгааг 7, 14, 30 хоногоор гаргаж аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралтад оруулж тодотгол хийн ажиллаж байна.	100
181		XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	МУЗГ, УОК, МХЕГ, ЭМЯ болон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн Засаг даргын 141 захирамж, 4 албан даалгаврыг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг холбогдох хуулийн хүрээнд тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Цар тахлын үед иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээр, хязгаарлалтын дэглэмж шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх аймгийн Гамшгийн эрсдэлийн санд урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион	100

			байгуулахад зарцуулах 800 сая төгрөгийн хөрөнгө тусгасан. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан бүх шатны төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ тогтоон санхүүжүүлэх арга хэмжээг авч, бүх сумд төсвийн байгууллагуудад холбогдох үүрэг чиглэлийг албан тоотоор өгч ажиллалаа. Монос, МЭЙК “Баруун-Урт” ЭХНБ-уудтай хариуцлагын гэрээ байгуулан мэргэжил арга зүйгээр ханган Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгалын бодисын нөөцийн судалгаа авч аймгийн нөөцийг 52 нэр төрлийн эм, хэрэгслийн 5-12 хоногийн тогтмол нөөц бүрдүүлэн Баасан гараг бүр УОК-ын Нэгдсэн Шуурхай штабт мэдээлж ажиллаж байна.	
182		XII.9.2. Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор 11-12 дугаар сард махны өргөтгөсөн худалдааг хүртээмжтэйгээр 30-аас доошгүй байршилд зохион байгуулах, шуудангийн хүргэлтийн үйлчилгээг ашиглан айл өрх өвлийн идшээ татан авах нөхцөлийг бүрдүүлж, хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт, уг ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Б.Бат-Эрдэнэ), Татварын ерөнхий газар (Б.Заяабал), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	“Махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тухай” ХХААХҮ-ийн сайдын А/319 тушаал, аймгийн Засаг даргын А/666 захирамжуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор “Өвлийн идэш” арга хэмжээнд Баруун-Урт сумын “Дарьт шүтээн” ХХК 85.0 тн, Сүхбаатар сумын 8 иргэн 68.0 тн, Эрдэнэцагаан, Мөнххаан сумын 4 иргэн 20.0 тн нийт 173.0 тн махыг хуваарьт газруудад худалдан борлуулсан.	100
183	2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2021-11-17 Дугаар 2021_60	XIII.2. . Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав: 1. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын	Гоц халдварт, халдварт өвчнөөс 4827300 толгой мал дархлаажуулалтад хамруулахаас Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/416 тоот захирамжаар Дарьганга, Уулбаян, Эрдэнэцагаан, Халзан, Баяндэлгэр, Онгон, Наран, Түвшинширээ сумын өвчлөмтгий нийт үхэр -191312, хонь-1059238, ямаа-694137 нийт- 1944687 толгой малд дархлаажуулалтын	100

		мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах өвчин оношлогдоод байгаа аймгуудын нутаг дэвсгэрт өвчнийг бүрэн хяналтад авах, устгах, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлыг эрчимжүүлж, мэргэжлийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт; 2. Өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг хангалтгүй бэлтгэсэн байдалдаа дүгнэлт хийж, өвс, тэжээлийн нөхөн бүрдүүлэлтээ шуурхай зохион байгуулахыг Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Увс аймгийн бүх шатны Засаг дарга нарт; 3. Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчний тархалт их байгаатай холбогдуулан мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдсан малыг улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжүүлж хаваржуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймаг, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт; 4. Отроор өвөлжиж, хаваржих малчдад эрүүл мэндийн болон төрийн бусад үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хөрөнгийг судалж шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, отор нүүдэлд хяналт тавих штабыг байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт.	арга хэмжээг зохион байгуулсан. Үхрийн арьс товруутах өвчин оношлогдсонтой холбогдуулан дархлаажуулалтад 240 өрхийн үхэр-13358, тугал-5310 нийт-18668 толгой мал хамрагдаж, нийт 160130 м/тун вакцин зарцуулж, хэвийн хорогдолд 5670м/тун вакцин устгаж, нийт 165800 м/тун вакцин хэрэглээд байна. -Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 9 нэр төрлийн вакцинд 1504,9 хамрагдахаас 1496,0 мянган мал хамрагдаж 99,4% ын гүйцэтгэлтэй хийгдсэн. -Бруцеллёз өвчний дархлаажуулалтад 5223 малчин өрхийн үхэр 65581, хонь 561802, ямаа 319020, нийт 946403 толгой мал хамрагдаж, 97,2 %-ийн гүйцэтгэлтэй хамрагдсан. Орчны болон бэлчээрийн эрүүл ахуйг сайжруулах ажлын хүрээнд нийт 36881 ш хүүр сэг зэм цуглуулан булж, бэлчээрийн 1055.4 м.кв талбай, өтөг бууц 351.8 м.кв, хашаа хороо 1.164.3 м.кв, худаг уст цэг 211.8 м.кв, 44 устгалын цэгийн 575.0 м.кв нийт 3.358.3 м.кв талбайд халдваргүйтгэл хийгдээд байна.	
184	2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр 62 дугаар тэмдэглэл 2021-12-01 Дугаар 2021_62	XI.3.3. Өвлийн идэш арга хэмжээг 12 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулахад зориулан Архангай аймаг 300.0 тонн, Баян-Өлгий аймаг 150.0 тонн, Говь-Алтай аймаг 100.0 тонн, Булган аймаг 247.0 тонн, Дорноговь аймаг 102.0 тонн, Дорнод аймаг 152.0 тонн, Дундговь аймаг 218.0 тонн, Завхан аймаг 146.0 тонн, Өвөрхангай аймаг 200.0 тонн, Өмнөговь аймаг 61.0 тонн, Сүхбаатар аймаг 160.0 тонн, Сэлэнгэ аймаг 84.0 тонн, Төв аймаг 326.0 тонн, Увс аймаг 365.0 тонн, Ховд аймаг 146.0 тонн, Хөвсгөл аймаг 395.0 тонн, Хэнтий аймаг 231.0 тонн гарал үүсэл нь баталгаатай эрүүл махыг тус тус тогтоосон хуваарийн дагуу өргөтгөсөн худалдаа болон хүнсний зах, худалдааны төвд тухай бүр нийлүүлэх талаар	“Махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тухай” ХХААХҮ-ийн сайдын А/319 тушаал, аймгийн Засаг даргын А/666 захирамжуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор “Өвлийн идэш” арга хэмжээнд Баруун-Урт сумын “Дарьт шүтээн” ХХК 85.0 тн, Сүхбаатар сумын 8 иргэн 68.0 тн, Эрдэнэцагаан, Мөнххаан сумын 4 иргэн 20.0 тн нийт 173.0 тн махыг хуваарьт газруудад худалдан борлуулсан.	100

		шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт.		
185	2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63	ХҮ.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт;	Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы үеэр өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг судалж, үр дүнг нийтэд мэдээлэх, үнийн хөөрөгдөлтэй холбоотой иргэдийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2021 оны 04 -сарын 06-ны өдрийн А/208 тоот захирамжаар байгуулсан_ Тус ажлын хэсэг 02 дугаар улиралд аймгийн хэмжээний хүнс, өргөн хэрэглээний барааны дэлгүүрүүдээс судалгаа авч, гомдлын дагуу газар аж ахуй нэгжийн газар дээр ажиллаж шалтгааныг тогтоон сошиалаар олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан. Мөн үнийн хөөрөгдөлтэй холбоотой гомдол авах хүлээн авах нээлттэй утсыг ажиллуулан иргэдийн гомдлын дагуу хариу өгч ажиллаж байна.	100
186	2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл 2021-12-14 Дугаар 2021_64	ХИҮ.5. . Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн хяналт шалгалтыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 50 хувиар бууруулах чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлэхийг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөв.	Аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөгөөр нийт 35 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хэрэгжүүлсэн бөгөөд 2022 оны төлөвлөгөөнд хяналт шалгалт хийх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг 50 хувь бууруулан ажиллахаар төлөвлөгөөндөө тусгасан. Татварын ерөнхий газраас чиглэл ирсэн болно.	70%
187		ХИҮ.5.2. . Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зайлшгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийх, хяналт шалгалтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгав.	Татварын хэлтэс нь 2021 оны хувьд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хэрэгжүүлсэн бөгөөд бүгд өөрсдийн хүсэлтээр оруулсан байна. Цаашид төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ цахим болон газар дээр нь хэрэгжүүлэх замаар ажиллахаар төлөвлөсөн болно. Төсвийн байгууллагууд болон бусад чиглэлээр эрсдэлд суурилсан хяналтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэхээр төрийн байгууллагуудад чиглэл өгч ажиллаж байна.	70%

188		ХИҮ.5.3. Бүх шатны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав.	Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд нийт 54 төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж холбогдох дүгнэлт, тайланг хүргүүлсэн байна. 2022 оны хувьд нийт төсвийн байгууллагад эрдлийн үнэлгээг хэрэгжүүлж хяналт шалгалт хийх төсвийн байгууллагын төлөвлөгөө, хуваарийг батлуулна.	70%
ЗГ-ын албан даалгавар				
189	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2019-05-01 Дугаар 2019_02	2.. “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг зохистойгоор хослон эрхлэх боломжийг бүрдүүлэх, орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн төрийн бүс байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын уялдаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараахь байгууллага, албан тушаалтанд дор дурдсан арга хэмжээ авахыг даалгаж байна: 2. Аймаг, сумын Засаг дарга, аж ахуйн нэгжийн удирдлагад: 2.1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал дүгнэлт, хүсэлтийг үндэслэн тухайн сум, багийн нутгийг тариалангийн бүсэд хамруулах тухай асуудлыг боловсруулан, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлж шуурхай шийдвэрлүүлэх; 2.2. Тариалангийн хөрсний үржил шимийг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, ургацыг малаас хамгаалах зорилгоор тариалангийн талбайг хашаажуулах ажлыг орон нутгийн тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх; 2.3. Тариалангийн бүс нутаг тогтоосонтой холбогдуулан орон нутгийн малчид, тариаланчдын саналыг үндэслэн цаашид зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, хамтран ажиллаж үр дүнд хүргэх; 2.4. Тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд	Нийт 34570.2га талбай бүхий тариалангийн бүс нутгийг аймгийн ИТХ-ын 60-аар тогтоолоор батлан ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Мөн тус мэдээллийг ГХБХБГ-ын тариалангийн мэдээллийн санд оруулсан.Тариалангийн бүс нутгийн 11000га талбайг дөрвөн улиралд тогтмол байх хэлбэрээр бүрэн хашаажуулсан.АЗД-ын 2021 оны "Тариалангийн талбайг малын хөлөөс хамгаалах,чөлөөлөх тухай" А/405-аар захирамжийн дагуу Түмэнцогт суманд үйл ажиллагаа явуулдаг “Хэрлэн алтай” ХХК 500га,“Газрын чимэг” ХХК 800га,нийт 1300га талбайг хашаажуулсан.Түмэнцогт,Сүхбаатар,Эрдэнэцагаан сумдын 27 малчидтай уулзаж ургамал ургалтын хугацаанд тариалангийн талбайг малын хөлөөс чөлөөлөх тухай хууль,ЗД-ын захирамжийг танилцуулсан.Таримлын сэлгээг жил бүр мөрдөж тариалангийн талбайн түүхийн тэмдэглэл хөтөлж байна.Тариалангийн хуулиар 5 жилд нэг удаа хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээг хийлгэх үүрэгтэй.Үүний дагуу 2018,2019 онуудад 7 үр тарианы аж ахуй нэгж 1 хоршоо өөрийн тариалангийн талбайд хөрсний шинжилгээ хийлгэсэн.Нийт 34570.2га тариалангийн талбайгаас 30800га талбайн бүрэн эзэмшилтэй байна. Атаршсан газрыг эзэмшүүлэх ажлыг орон нутгийн түвшинд гүйцэтгэж 30800га талбайг үр тариа, төмс, хүнсний ногооны зориулалтаар үр тарианы 7 аж ахуй нэгж,168 иргэн,5 хоршоо,5 байгууллага атаршсан талбайг эзэмшиж ашиглаж байна. Түмэнцогт суманд Үргэлж бадрал ХХК,Хэрлэн Алтай ХХК,Түмэнцогт ургац ХХК,Газрын чимэг ХХК, Сүхбаатар суманд Дорнод шим агро ХХК, Эрдэнэцагаан суманд Номин богд ХХК-иуд 11630.30 га талбайд тариалалт хийсэн нь өмнөх	100

		өөрийн эзэмшлийн тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулахад чиглэсэн техник, технологи, таримлын сэлгээг нэвтрүүлж, нутагшуулах, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хөрсний үржил шимийн иж бүрэн шинжилгээг хуульд заасны дагуу тогтмол хийлгэх; 2.5. Тариалангийн бүс нутагт эрчимжсэн загвар аж ахуйг бий болгоход хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; 2.6. Тариалангийн бүс нутаг дахь малчдын шилжилт хөдөлгөөнд зохицуулалт хийж, бүс нутгаас нүүж гарах малчдад эдийн засгийн урамшуулал үзүүлэх; 2.7. Тариалангийн талбайн эзэмшил ашиглалтыг сайжруулах, атаршсан болон өнжмөл талбайг эргэлтэд оруулах чиглэлээр арга хэмжээ авах; 2.8. Тариалангийн бүс нутагт тариаланчид малчдын зөвлөлдөх уулзалтыг бүсчлэн зохион байгуулж, түүнээс гарсан санал дүгнэлтийг нэгтгэн хэрэгжүүлэх;	оныхоос 5577.3га-аар нэмэгдсэн нь нийт тариалангийн талбайн 37 хувь буюу өмнөх оноос 19.4 хувиар нэмэгдсэн.Түмэнцогт,Сүхбаатар,Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй үр тарианы аж ахуй нэгжүүд төлөөлөл, малчдыг байлцуулан ургамал ургалтын хугацаанд тариалангийн талбайг малын хөлөөс чөлөөлөх талаар чиглэл АЗД-ын А/405 тоот тариалангийн талбайг малын хөлөөс чөлөөлөх,талбайг хашаажуулах тухай захирамжийг танилцуулав.	
190	Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор, нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай 2020-02-10 Дугаар 2020_01	1.. Хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэж халдваргүйтгэх, “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг болон “Журам, чиглэл батлах тухай” Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжлүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас дараах албан даалгаврыг өгч байна: Нэг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт: 1.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж гарган харьяалах нутаг дэвсгэртээ хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах;	Орчны болон бэлчээрийн халдваргүйтгэлд: өтөг бууц 351.8, хашаа хороо 1.164.3, худаг уст цэг 211.8, бэлчээрийн талбай 1.055.4, устгалын цэг 275.0 нийт 3.144.8 м.кв талбайд халдваргүйтгэл хийгдсэн. Халдваргүйтгэлийн бодисын захиалгыг МЭЭГ-т хүргүүлэн эмийн бодис татан авч, цаг тухай бүрт нь зарцуулалтын тайланг гарган ажиллаж байна. Халдварт, гоц халдварт, зооноз өвчнөөс эрүүл тайван статус батламж авах ажлын хүрээнд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан “Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам”-ын дагуу Түмэнцогт сумын 3 малчны бүлгийн 12 малчин өрхөд гоц халдварт шүлхий, бог малын мялзан, цэцэг, халдварт зооноз бруцеллөз, сүрьеэ өвчингүй тайван бүс, нутаг дэвсгэрийг баталгаажуулах судалгаа, оношлогоо, шинжилгээг	100

			заавар, арга зүйн дагуу хэрэгжүүлсний үндсэн дээр тайван эрүүл сүрэгтэн батламж олгосон.	
191		1.2. Мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж, уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулах, мөн олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэн энэ ажлын зорилго ач холбогдлыг өргөн сурталчлах;	Сумдын засаг дарга нартай халдваргүйтгэлийн арга хэмжээг сум орондоо зохион байгуулах талаар гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.	100
192		1.3, 1.4, 1.5. 1.3 Харьяалах нутаг дэвсгэрт отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх чиглэл, хугацааг тогтоож, хяналт тавих; 1.4 Отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсгийг томилж, үүрэгжүүлэх; 1.5 Отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийх явцад болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг, зэмийг цуглуулах, устгах, халдваргүйтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Аймгийн хэмжээнд адуу 1265, үхэр 2491, тэмээ 21, хонь 13449, ямаа 14819, нохой 1035 нийт 33080 ширхэг мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж, зориулалтын нүхэнд булж, халдваргүйтгэлийг зааврын дагуу хийж ажилласан	100
193		1.6.. Байгаль, цаг уурын аюултай үзэгдэл болох /цасан болон шороон шуурга/ гэх мэт гарч болзошгүй эрсдлээс урьдчилан цаг алдалгүй сэрэмжлүүлж байх;	Аймгийн Цаг уур, орчин шинжилгээний хэлтсийн гаргасан мэдээг Мал эмнэлгийн тасгийн болон Хүнс, хөдөө аж ахуйн тасгийн дотоод цахим групп хаягаар шуурхай зар пост оруулан сэрэмжлүүлдэг.	100
194		1.7.. 1.7 Хүндэрч болзошгүй сумдад өвс тэжээлийн нөөцийг цаг алдалгүй хүргүүлэх; 1.8 Хаагдаж болохуйц зам даваанд тогтмол пост гарган хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах;	Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар өвөлжилт хэвийн байгаа хэдий ч зарим сумдад /Дарьганга, Наран, Түмэнцогт, Эрдэнэцагаан/ 5- 10 см зузаан цастай бог мал доороосоо ширвэгдэх нөхцөл үүсээд байгаа тул засгийн газрын 221 дүгээр тогтоолоор бэлтгэсэн өвсийг аймгийн Засаг даргын А/ 763 дугаар захирамжаар сумдын малчдад олгоод байна.	100
195		1.9.. 1.9 Мал эмнэлгийн нэгдсэн системийг орон нутагтаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, төсөв хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх; 1.10 Дээрх үйл ажиллагаатай холбоотой ажлыг зохион байгуулахад мал эмнэлгийн ажил, үйлчилгээний төрийн болон хувийн хэвшлийн нэгж, тасаг, хяналтын	Мал эмнэлгийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэн ашиглаж байгаа бөгөөд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт гүйцэтгэл, мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ бүхий л мэдээллийг нэгдсэн системээр олгон ажиллаж байна. Системийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2020, 2021	100

		цэг, онцгой байдал, мэргэжлийн хяналт, авто тээврийн хяналтын болон эрүүл мэндийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, хамтран ажиллах.	онуудад Дижитал медик компанитай хамтран ажиллан нийт сумдын мал эмнэлгийн тасаг, сумдын нэгжийн эмч нарт таблет, мини принтерийг олгон ажилласан.	
196		2.. Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт: 2.1 Улсын хэмжээнд мал, амьтны сэг зэмийг устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гарган, нэгдсэн заавар, удирдамжаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; 2.2 Мал, амьтны сэг зэмийг өвөлжөө, хаваржаа, хашаа, хорооноос 500 метрээс доошгүй зайтай газарт автомашин, ус үерийн замаас зайдуу гүн нүхэнд булах буюу шатааж устгах; 2.3 Малын хашаа хорооны өтөг бууцыг сийлж овоолон, биотермийн аргаар халдваргүйтгэх; 2.4 Булаг, шандны эхийг цэвэрлэж, тойруулан хаших, малын ялгадас, бороо, цасны ус орохоос хамгаалсан суваг, шуудуу татах арга хэмжээ авахуулах; 2.5 Цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн ажлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалт, семинар зохион байгуулах; 2.6 Орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах, малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанар, аюулгүйн шаардлага хангасан ариутгал халдваргүйтгэлийн бодис, бэлдмэлийн нөөц бүрдүүлэн, хангамжийг сайжруулж ажиллах; 2.7 Отор нүүдэл хийх чиглэл, хугацаа, нутаг дэвсгэрийг тогтооход мал эмнэлгийн тархвар зүйн судалгаанд үндэслэн үнэлгээ, дүгнэлт өгөх; 2.8 Отор нүүдлийн зорилгоор мал амьтны шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд мал эмнэлгийн гэрчилгээг үндэслэн саналаа бичгээр гаргаж, дээд шатны Засаг захиргааны байгууллагад мэдэгдэж, шийдвэр гаргуулах; 2.9 Отор нүүдлээр харьяалах нутаг дэвсгэрт ирсэн мал, амьтанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн газрын даргын 2021.03.03 А/06 тоот тушаал, 2021.05.19 1/65 тоот зөвлөмж, ажлын удирдамжийг гаргаж сумдад хүргүүлэн, отор нүүдэл, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж зориулалтын устгалын цэгт цуглуулан булж, хувийн хэвшлийн байгууллага, малчид, мал амьтан өмчлөгч иргэдтэй хамтран орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.Сүхбаатар аймагт 2021оны 01/01-11/26-ны хооронд отор нүүдэл шилжилт хөдөлгөөнөөр Сүхбаатар аймагт ирсэн адуу -3010, үхэр -613, хонь-2292, ямаа-2197, тэмээ-84 нийт 8196 мал 337 гэрчилгээгээр 13 суманд ирээд байгааг сумдын мал эмнэлгийн байцаагч нар уулзах, утсаар холбогдох зэргээр хяналт тавьж зөвлөмж өгч, МЭҮНэгжүүд мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг тогтмол хийж, халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулан ажиллаж байна.Өвөрхангай аймгийн Гучин ус сумын 4 өрх, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын 1 өрхийн 3274 толгой малд эрүүл мэндийн үзлэг хийж шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулаад байна.Отор нүүдлээр ирсэн мал амьтныг мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан эсэхд хяналт тавин хамрагдаагүй тохиолдолд тухай отроор ирсэн мал сүргийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулан ажилласан.	100

		2.10 Мал амьтныг хүлээж авах, шилжүүлэх үед эрүүл мэндийн үзлэгийг хийж баталгаажуулах, мал эмнэлгийн цахим системд мэдээллийг бүрэн оруулах; 2.11 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг цаг хугацаанд нь зохион байгуулаагүй, зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож байх.		
197		3.. Малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд: 3.1 Мэргэжлийн байгууллагын заавар, удирдамжийн дагуу мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн ажилд идэвхтэй оролцох; 3.2 Малын хашаа хороог цэвэрлэх, хөрзөнг гадагш гаргаж хураах ажлыг 05 дугаар сарын 15-ны дотор гүйцэтгэж, халдваргүйтгэл хийх; 3.3 Өвөлжөө, хаваржааны ойр орчимд байгаа мал, амьтны сэг, зэмийг цуглуулан устгах, булах, уст цэг, булаг шандны эхийг цэвэрлэх, хамгаалах ажлыг гэрээт мал эмнэлгийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран гүйцэтгэх;	Мал эмнэлгийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэн ашиглаж байгаа бөгөөд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт гүйцэтгэл, мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ бүхий л мэдээллийг нэгдсэн системээр олгон ажиллаж байна. Системийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2020, 2021 онуудад Дижитал медик компанитай хамтран ажиллан нийт сумдын мал эмнэлгийн тасаг, сумдын нэгжийн эмч нарт таблет, мини принтерийг олгон ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн газрын даргын 2021.03.03 А/06 тоот тушаал, 2021.05.19 1/65 тоот зөвлөмж, ажлын удирдамжийг гаргаж сумдад хүргүүлэн, отор нүүдэл, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж зориулалтын устгалын цэгт цуглуулан булж, хувийн хэвшлийн байгууллага, малчид, мал амьтан өмчлөгч иргэдтэй хамтран орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ. Орчны болон бэлчээрийн эрүүл ахуйг сайжруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 36881 ширхэг мал, амьтны хүүр сэг зэмийг цуглуулан булж, бэлчээрийн 1055.4 м.кв талбай, өтөг бууц 351.8 м.кв, хашаа хороо 1.164.3 м.кв, худаг уст цэг 211.8 м.кв, 44 устгалын цэгийн 575.0 м.кв нийт 3.358.3 м.кв талбайд халдваргүйтгэл хийгдсэн.	100
198	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн	2020 оны 12-р сарын 22-ны 3/1246 тоот албан бичгээр төслийг хүргүүлж хэрэгжилтийг хангасан.	100

		бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;		
199		1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх;	2020 оны 12-р сарын 22-ны 3/1247 тоот албан бичгээр төлөвлөгөө, үйлчилгээний жагсаалтыг хүргүүлснээр 12 төрийн байгууллагын 76 үйлчилгээг цахимжуулж e-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн системд нэгтгэх ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 03-ны өдрийн хооронд зохион байгуулсан.	100
200		1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх;	12 төрийн байгууллагын 76 үйлчилгээг цахимжуулж e-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн системд нэгтгэх ажлыг зохион байгуулж дахин загварчлах, шийдвэрлэх эрх үүсгэх, системийн тохируулга хийх сургалтыг 13 сумын оператор болон байгууллагын админ албан хаагчдад танхимаар хийсэн. Цахим үйлчилгээг үзүүлж байна.	100
201		1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх;	e-mongolia системээс гарч буй нэг шатлалт лавлагаа үйлчилгээтэй холбоотой ямар нэг гомдол ирээгүй. 2 шатлалт үйлчилгээ цахим үйлчилгээний нэгдсэн системд нэгдсэнээр тухайн лавлагаа тодорхойлолт гаргах байгууллагын ерөнхий админ үйл ажиллагааг байнга хянаж байхаар тохируулга хийгдсэн. Тухайн лавлагаа тодорхойлолтыг цаг хугацаанд нь шийдвэрлэж байх чиглэл өгөгдсөн.	100
202		1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Аймгийн хэмжээнд тоон гарын үсгийн ашиглалт 10% орчим байна. Төрийн байгууллагуудын гарын үсэг зурах эрх бүхий албан хаагчдыг тоон гарын үсэгтэй болгох, хувийг нэмэгдүүлэх талаар чиглэл өгөгдөж, Аймгийн ИТХ, ЗДТГазрын бүх албан хаагчдыг цахим гарын үсэгтэй болгох талаар хүсэлт гаргаж захиалга өгсөн.	100
203		1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах;	Олон шатлалт үйлчилгээ нэвтэрсэнтэй холбоотойгоор төлбөртэй лавлагаа тодорхойлолтын төлбөрийг тухайн байгууллагын дээд шатны байгууллагаас гаргасан хууль, журамд заасны дагуу боломжит хувилбараар төлбөрийг тогтоосон.	100

204		1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах;	Харилцаа холбоо мэдээллийн технологийн газартай албан бичиг болон цахим шуудан, бодлого хариуцсан мэргэжилтнүүдтэй байнгын хамтын ажиллагаатай ба ХУР системийн ачаалал болон гарсан алдааны талаар мэдээллийг байнга солилцож хамтран ажилладаг.	100
205		1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	Цахим үйлчилгээний талаарх контент, гарын авлага, брошур зэргийг аймгийн тамгын газартай хамтран ажилладаг sbinfo.mn сайт Сүхбаатарын өнгө сонин, BBS телевиз болон өөрийн албан ёсны фэйж хуудсаар тогтмол түгээдэг. Мөн бүх сумдын операторуудад дээрх контентуудыг өгч тухайн сумдын олон нийтийн сүлжээгээр тогтмол түгээдэг	100
206	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	Үндэсний дата төвөөс албан хэрэг хөтлөлтийн docx.gov.mn программ хангамжийг авч төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн албан бичиг модульд холбосон.	100

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХЦЭЦЭГ

ТАЙЛАНД ҮНЭЛГЭЭ ӨГСӨН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.ХУРЦБАЯР

ТАЙЛАНД ХЯНАСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.БААСАНДОРЖ